



ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ – 2022

Улаанбаатар хот
2022 он

СУДАЛГААНЫ БАГ

Н.АЛТАНЦЭЦЭГ	“ОЮУНЫ ЦЭЛМЭЛТ” НҮТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, НИЙГМИЙН УХААНЫ БАГШ, СУДЛААЧ
Т.ЧИМЭГСАНАА	“ОЮУНЫ ЦЭЛМЭЛТ” НҮТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, БАГШ, ЭДИЙН ЗАСАГЧ, БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН МАГИСТР, ДОКТОРАНТ
Я.ХИШИГТ	“ОЮУНЫ ЦЭЛМЭЛТ” НҮТББ-ЫН ЗӨВЛӨХ, БАГШ, ЭРХ ЗҮЙЧ, МАГИСТР
Д.ХИШИГБАЯР	“ОЮУНЫ ЦЭЛМЭЛТ” НҮТББ-ЫН ГИШҮҮН, ЭДИЙН ЗАСАГ, НЯГТЛАН БОДОГЧ /Мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн аудитор/

Энэхүү “Хэрэглэгчийн үнэлгээ” судалгааны ажлыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захиалгаар “Оюуны цэлмэлт” НҮТББ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг удирдлага болгон 2022 оны 12 дугаар сарын ...-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хооронд гүйцэтгэв.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН БОЛОН ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

НЭГ. УДИРТГАЛ

- 1.1. Судалгааны ажлын зорилго, зорилт
- 1.2. Судалгааны ажлын арга, аргачлал
- 1.3. Судалгааны хамрах хүрээ
- 1.4. Түүврийн хэмжээ ба респондентууд
- 1.5. Асуулгын бүтэц, боловсруулалт
- 1.6. Судалгааны зохион байгуулалт

ХОЁР. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

- 2.1. ШШҮХ-ийн үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ
- 2.2. ШШҮХ-ийн бодлого, үйл ажиллагааны ханамжийн судалгаа
- 2.3. ШШҮХ-ийн үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ

ГУРАВ. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ТАЛААРХ ҮНЭЛГЭЭ

- 3.1. ШШҮХ-ийн мэдээллийн ил тод байдал, хүртээмжийн үнэлгээ

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

ХАВСРАЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН БОЛОН ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ:

Хүснэгт 1.Суурь болон ажиглалтын судалгаа

Хүснэгт 2.Түүврийн бүтэц

Хүснэгт 3.Судалгаанд оролцсон Төрийн албан хаагчдын хүн ам зүйн мэдээлэл

Хүснэгт 4.Судалгаанд оролцсон иргэдийн хүн ам зүйн мэдээлэл

Хүснэгт 5.Анкетын асуулгын бүтэц /Анкет-А/

Хүснэгт 6.Анкетын асуулгын бүтэц /Анкет-Б/

Хүснэгт 7. Иргэд оршин байгаа газраа хэр аюулгүй, амгалан тайван байгаа байдал, үйлчилгээний түргэн шуурхай байдал, хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилт

Хүснэгт 8-11. Судалгааны үр дүнгийн хүснэгтүүд

ЗУРГИЙН ЖАГСААЛТ:

Зураг 1.Үйл ажиллагааны дараалал

Зураг 2. Судалгааны төрөл, мэдээлэл цуглуулах арга

Зураг 3. Хэрэглэгчийн түвшин (NPS)

Зураг 4. Түүврийн томьёо

Зураг 5. Судалгааны үзүүлэлт

Зураг 6-12. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн үр дүнгийн үзүүлэлт

НЭГ. УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлаас хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг 2020 онд шинэчлэн баталж мөрдүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газраас хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулан журамласан.


Журамд төрийн захиргааны байгууллагууд жил бүр үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэдээс сэтгэл хамнамжийн судалгаа авах ажлыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэхээр тусгасан нь дэлхийн улс орнуудын Засгийн газрын нэгэн адил сайн засаглал, хариуцлага, ил тод байдал, хөгжлийн илүү үр дүнд хүрэх, бодит үр дүнг бий болгох талаар оролцогч талуудаас тавьж буй шахалт шаардлагад мэдрэмжтэй хандах болсны тод илрэл юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг удирдлага болгон тус судалгааны ажлыг хийв.

Шүүхийн шинжилгээний байгууллагын 2022 онд хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судлах, түүнд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлох энэхүү ажлыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захиалгаар “Оюуны цэлмэлт” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын үнэлгээний баг гүйцэтгэлээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2022 оны хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлын удирдамж болон ажил гүйцэтгэхэд баримталсан зарчимтай уялдуулан үнэлгээг дараах үе шаттайгаар явуулсан.

Зураг 1. Үйл ажиллагааны ерөнхий дараалал



1.1. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж” зэргийг тус тус үндэслэл болгов.

Ажлын зорилго нь Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судлах, түүнд дүн шинжилгээ хийж, цаашид

хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

Зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тодорхойлж үнэлгээ хийв. Үүнд:


- Бодлого, үйл ажиллагаа иргэдэд хүрсэн байдлыг үнэлэх;
- Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар иргэдийн саналыг авах, судлах;
- Иргэдээс авсан санал асуулгын дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж өгөх зорилтуудыг дэвшүүлсэн болно.

1.2. СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА, АРГАЧЛАЛ

Үнэлгээнд хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд өргөн хэрэглэгддэг тоон болон чанарын судалгааны загвар, арга зүйг хослуулан хэрэглэсэн.

Тоон судалгаагаар статистик арга, аргачлалын дагуу түүвэрлэн авсан хүнээс тусгайлан бэлтгэсэн асуултуудыг багтаасан асуулга авч, иргэдийн санал, хүсэлт, шийдвэрлэх арга зам, хэрэгжүүлэх үйл ажиллагааг илүү нарийн, өргөн хүрээнд, үр дүнтэй судлах зорилгоор чанарын судалгаагаар баримт бичиг шинжлэх, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулав.

Зураг 2. Судалгааны төрөл ба мэдээлэл цуглуулах арга



Санал асуулгаар 2022 онд Шүүхийн шинжилгээний байгууллагаас үйлчилгээ авсан болон цагдаагийн байгууллагатай холбоотой асуудлаар харилцсан иргэдээр тухайн байгууллагаас хэрэгжүүлсэн захиргааны байгууллагаас хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, найдвартай үр дүнтэй, хүртээмжтэй байдал, албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй, үйлчилгээ үзүүлж байгаа орчин нөхцлийн тав тухтай байдал, шаардлагатай техник, тоног

төхөөрөмжийн хангамж хүрэлцээг үнэлүүлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйлчилгээг сайжруулах арга замын талаарх иргэдийн байр суурийг шинжилж үнэлэлт дүгнэлт хийлээ.

Асуулгын хуудсыг (хавсралт 2) ерөнхий удирдамжийн хоёрдугаар хавсралтаар баталсан “Иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах санал асуулгын хуудасны ерөнхий загвар”, олон улсын хэмжээнд түгээмэл хэрэглэдэг аргачлалд тулгуурлан 2 бүлэг ... асуултайгаар боловсруулж, ерөнхий удирдамжид заасан аргачлалаар үнэлгээг тооцож тодорхойлохын тулд үзүүлэлт бүрийг 1-маш муу, 2- муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн, 0-мэдэхгүй, хариулах боломжгүй гэсэн сонголтууд бүхий 5 хүртэл оноотойгоор боловсруулсан болно.

Баримт бичгийн судалгаанд холбогдох дараах баримт бичигт дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгох чиглэлээр авч хэрэгжүүлж ирсэн арга хэмжээ, холбогдох баримт бичиг, тайлан;
- Холбогдох статистик, тоо, мэдээ, үйл ажиллагааны тайлан;
- Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, тэдгээрийн шийдвэрлэлт;
- Шүүхийн шинжилгээний байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд контент.

Ганцаарчилсан ярилцлагаар санал асуулгын судалгааны мэдээллийг гүнзгийрүүлэн шалгах, учир шалтгааныг нь тодорхойлох зорилготойгоор алба хаагч, үйлчилгээ авсан болон аваагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, шүүгч, прокурор зэрэг субъектийг хамруулан хэрэглэж үзүүлж буй үйлчилгээ, түүнд гарч буй ахиц дэвшил, алдаа дутагдал, өөрчлөлт, тулгамдаж буй асуудлыг үнэлүүлж, дүгнэлт боловсруулахыг зорьсон.

Фокус бүлгийн ярилцлагаар үнэлгээнд оролцсон иргэн, хохирогчийн төлөөллийг хамруулан шүүхийн шинжилгээний байгууллагын талаарх төсөөлөл, ойлголт, хандлагыг судаллаа.

Хүснэгт 1. Суурь болон ажиглалтын судалгаа

Д/д	Судалгааны багц	Судалгааны төрөл	Түүвэр дэх шалгуур
1	Суурь судалгаа	Асуулга судалгаа	Сонгосон дүүргийн иргэд, төрийн албан хаагчид
		Анкет судалгаа	Асуулгын асуултыг илүү нарийвчилсан байдлаар алба хаагчид болон экспертүүд, иргэнээс учир шалтгааныг тодруулсан нэмэлт тодруулга авсан.

2	Ажиглалтын судалгаа	Цахим хуудасны шинжилгээ	Цахим хуудсанд тодорхой шалгуураар үнэлгээ хийх
---	---------------------	--------------------------	---


Хэрэглэгчийн итгэл үнэмшлийг хэмжих зорилгоор “Шүүхийн шинжилгээний байгууллагаас иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдал өмнөх жилтэй харьцуулахад хэр ахиц гарсан бэ?” гэсэн асуултад -10 оноо, огт санал болгохгүй -0 буюу 0-10 онооноос сонголт хийлгэсэн.

Хариултын онооноос шалтгаалан хэрэглэгчийг гурван түвшинд авч үзсэн. Үүнд:


1. Дэмжигч хэрэглэгч (9-10 оноо)
2. Эргэлзэгч хэрэглэгч (7-8 оноо)
3. Үл итгэгч (0-6 оноо).

Үр дүнг хэмжигч хэрэглэгч (9-10 оноо)-ийн хувиас үл итгэгч хэрэглэгч (0-6 оноо)-ийг хасаж хэрэглэгчийн өсөлт, итгэнл үнэмшил, үнэнч байдлыг тооцсон. Итгэл үнэмшил, үнэнч байдлын утга сөрөг тэмдэгтэй гарч болно. Энэ нь сөрөг мэдээллийн итгэгдэх байдал, бусдад мэдээллийн тархах байдал илэрхийлсэн хувиар тарах магадлал байгааг харуулна.

Зураг 3. Хэрэглэгчийн түвшин (NPS)



Net Promoter Score



1.3. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ:

Түүврийн харьцааг 70:30 байхаар тооцсон бөгөөд судалгаанд оролцсон иргэдийн 68% нь УБ хотын иргэд, 32% нь төрийн албан хаагч байгаа тул түүврийн бүтэц хангагдсан гэж үзсэн.

Тус судалгааны анкет судалгаанд 367 иргэн хамрагдсан. Шүүхийн шинжилгээний байгууллагын талаар хуульчдаас 72 хүн оролцсон. Мөн экспертийн түвшинд судлаач 3 үүнээс PhD 2, төрийн албаны удирдах болон ахлах түвшиний иргэд нийт 6 хүнтэй ярилцлага хийх замаар чанарын судалгааг авсан болно.

1.4. ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ БА РЕСПОНДЕНТУУД

Судалгааны түүвэрлэлтийг хийхдээ эх олонлогийг хэвийн тархалттай гэж үзэн энгийн санамсаргүй түүврийн аргыг ашигласан. Түүврийн хэмжээг тогтоохдоо дараах томъёог ашиглав.

Зураг 4. Түүврийн томъёо


$$n = \frac{t^2 \cdot w \cdot (1 - w) \cdot N}{N \cdot \Delta_p^2 + t^2 \cdot w \cdot (1 - w)}$$

Түүврийн хэмжээ 95%-ийн итгэх магадлалтай, +/- 5%-ийн алдааны хязгаартай байхаар тооцож оновчтой түүврийг нийт 367 хүн гэж тогтоов. Төрийн албан хаагч хуульчийн хувьд түүврийг 72 хүн гэж тооцов.

Хүснэгт 2. Түүврийн бүтэц

Алба хаагчид

Байгууллага	Тоо	Хувь
ЦЕГ	19	26.4%
ТЦА	10	13.6%
МШУТ	13	19%
Бусад	30	41.0%
Нийт	72	100%



Иргэд

Аймаг, нийслэл	Дүүрэг	Тоо	Хувь
УБ хот	БГД	35	9.5%
УБ хот	БЗД	39	10.6%
УБ хот	СБД	35	9.5%
УБ хот	СХД	38	10.3%
УБ хот	ХУД	28	7.6%
УБ хот	ЧД	31	8.4%
ХЗДХЯ		40	11%
ТЦА		27	7.4%
ГХУСАЗЗ		41	11.2%
Хүчирхийллийн эсрэг тэмцэх ТББ		20	5.4%
ХЭҮК		18	4.9%
МӨХ		15	4.2%
НИЙТ		367	100%



shutterstock.com · 1389841955

Албан хаагчдын судалгаанд нийт 72 хүн хамрагдсан, 31% нь эмэгтэй, 69% нь эрэгтэй насны хувьд 36-45 настай 41%, 46-аас дээш настай 29%, 26-35 настай 27%, 18-25 настай 2% нь эзэлж байна.

Хүснэгт 3. Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдийн хүн ам зүйн мэдээлэл

Асуулт	Хариулт	Тоо	Хувь
Насны бүлэг	18-25 нас	7	11%
	26-35 нас	28	38%
	36-45 нас	26	36%
	46-аас дээш нас	11	15%
	Нийт	72	100%
Хүйс	Эмэгтэй	22	31%
	Эрэгтэй	50	69%
	Нийт	72	100%

Боловсрол	Бүрэн дунд /10/11/12 анги/	6	8%
	Дээд /Бакалавр/	33	46%
	Дээд /Доктор/	4	6%
	Дээд/Магистр/	29	40%
	Нийт		100%

Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд 367 он хамрагдсанаас 12 анкет хүчингүй болж 355 иргэн хамрагдсан. Үүний 61% нь эмэгтэй, 39% нь эрэгтэй, насны бүлгээр харвал 11% нь 18-25 настай, 25% нь 26-35 настай, 36% нь 36-45 настай, 29% нь 46-аас дээш настай иргэд байна. Боловсролын хувьд 78% нь дээд, 13% нь бүрэн дунд, 4% нь техник болон мэргэжлийн дунд (МСҮТ), 3% суурь /8,9 анги/ боловсролтой, үлдсэн 2% нь боловсролгүй/бага гэсэн ангилалд хамаарагдаж байна.

Ажил эрхлэлтийн байдлыг харвал 90% ажил хөдөлмөр хийдэг, үүний 40% нь төрийн байгууллагад ажилладаг ба ажилгүй иргэд 8%-ийг эзэлж байна.

Хүснэгт 4. Судалгаанд оролцсон иргэдийн хүн ам зүйн мэдээлэл

Асуулт	Хариулт	Тоо	Хувь
Насны бүлэг	18-25 нас	39	11%
	26-35 нас	89	25%
	36-45 нас	128	36%
	46-аас дээш нас	99	28%
	Нийт	355	100%
Хүйс	Эмэгтэй	110	31%
	Эрэгтэй	245	69%
	Нийт	355	100%
Боловсрол	Бага, бүрэн дунд, МСҮТ	78	22%
	Дээд /Бакалавр/	164	46%
	Дээд /Доктор/	7	2%
	Дээд/Магистр/	106	30%
	Нийт	355	100%
Ажил эрхлэлт	Ажилгүй	28	8%
	Төрийн байгууллага	142	40%
	ТББ/Олон улсын байгууллага	10	3%
	Хувийн хэвшил, компани	71	20%
	Хувиараа бизнес эрхэлдэг	50	14%
	Малчин, тариаланч	4	1%
	Бусад	46	13%
	Хариулаагүй	4	1%
	Нийт	355	100%

1.5.АСУУЛГЫН БҮТЭЦ, БОЛОВСРУУЛАЛТ

Шүүхийн шинжилгээний байгууллагын 2022 оны хэрэглэгчийн үнэлгээний судалгааны асуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг үндэслэл болгон боловсруулсан. Анкетын судлагаа –А нийт зургаан бүлэг 72 асуулттай. Судалгааг мэдээллийг IBM SPSS 23.0 программ ашиглан боловсруулав.

Хүснэгт 5. Анкетын асуулгын бүтэц /Анкет- А/

Бүлэг	Асуултын тоо	Агуулга
I бүлэг	16 асуулт	Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд өгсөн ерөнхий сэтгэл ханамжийн үнэлгээ, иргэдийн оролцоо, мэргэжил арга зүйн туслалцаа хэр үзүүлдэг, техник технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа хэр ашигладаг, алба хаагчид авилгаас ангид шударга ажиллаж байгаа байдал, үйл ажиллагааны шуурхай байдал, алба хаагчдын харилцаа хандлагын үнэлгээ, санал гомдолд хариу өгөх байдал зэрэгт өгөх үнэлгээ
II бүлэг	8 асуулт	Шүүхийн шинжилгээний байгууллагатай хамтын ажиллагаатай байгууллагуудад өгөх сэтгэл ханамжийн үнэлгээ, бодлого шийдвэрүүд хэр ил тод нээлттэй байгаа, эдгээр байгууллагуудын талаарх мэдээлэл, үйл ажиллагааны үнэлгээ, шуурхай байдал, ажилтнуудын харилцаа, хандлага, санал гомдолд хариу өгөх байдал, залгамж холбоо зэрэг асуудлын үнэлгээ
III бүлэг	7 байгууллагын 6 асуулт	Үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, нээлттэй байдал, авилгаас ангид шударга байдал, түргэн шуурхай байдал, албан хаагчдын хандлага, гадна, дотно тохижилт, үйлчилгээний ая тухтай орчинг бүрдүүлсэн байдлын үнэлгээ
IV бүлэг	22 асуулт	Хууль, дүрэм журам хүн бүрт тэгш үйлчилж байгаа эсэх, хуулийн төсөлд хэр оролцдог, иргэд шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд хэр хяналт тавьж байгаа байдал, үйлчилгээний шуурхай байдал, тусламж шаардлагатай үед хэнд хаана хандахаа хэр сайн мэдэх зэрэг асуудлуудыг үнэлэх
V бүлэг	14 асуулт	Үйлчилгээний чанар хүртээмж, алба хаагчдын харилцааны соёл, ёс зүй болон үйлчлүүлсэн байгууллагын орчны үнэлгээ, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдлын өмнөх жилтэй харьцуулсан ахицын үнэлгээ, Шүүхийн шинжилгээний

		байгууллагын үйл ажиллагааг сайжруулахын тулд хүсч буй ажил болон өмнөх жилээс үр дүнтэй ажлыг үнэлэх
VI бүлэг	5 асуулт	Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Анкетын судлагаа –Б нийт зургаан бүлэг 55 асуулттай. Судалгааг мэдээллийг IBM SPSS 23.0 программ ашиглан боловсруулав.

Хүснэгт 6. Анкетын асуулгын бүтэц /Анкет- Б/

Бүлэг	Асуултын тоо	Агуулга
I бүлэг	6 асуулт	Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл
II бүлэг	16 асуулт	Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд өгөх үнэлгээ, үйл ажиллагааны нээлттэй байдал, техник технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа хэр ашигладаг, алба хаагчид авилгаас ангид шударга ажиллаж байгаа байдал, алба хаагчдын харилцаа хандлагын үнэлгээ, санал гомдолд хариу өгөх байдал зэрэгт өгөх үнэлгээ
III бүлэг	7 байгууллагын 6 асуулт	Шүүхийн шинжилгээний байгууллагатай хамтын ажиллагаатай байгууллагуудад өгөх үнэлгээ, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, нээлттэй байдал, авилгаас ангид шударга байдал, түргэн шуурхай байдал, албан хаагчдын хандлага, гадна, дотно тохижилт, үйлчилгээний ая тухтай орчинг бүрдүүлсэн байдлын үнэлгээ хийх
IV бүлэг	27 асуулт	Иргэдийн оролцоо, аюулгүй байдал, хууль, дүрэм журам хүн бүрт тэгш үйлчилж байгаа эсэх, амьдарч буй орчны аюулгүй байдлын үнэлгээ, үйлчилгээний түргэн шуурхай байдлыг үнэлэх

1.6. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгааны ажил нь гэрээний дагуу хийгдсэн ба цахим бүлжээний сүүлийн үеийн дэвшилтэд технологийг ашиглах замаар цахим болон 2022 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс 11 дүгээр сарын ...-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Чанарын судалгааны мэдээллийг 2022 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс ... дугаар сарын ...-ны өдрүүдэд ганцаарчилсан ярилцлагын аргыг ашиглан утсаар ярилцаж цуглуулсан болно.

ХОЁР. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Шүүхийн шинжилгээний байгууллага нь 2022 онд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ болон Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлого, чиглэлтэй уялдуулан **“Байгууллагын ажил үйлчилгээний чанарын түвшинг нэмэгдүүлж, цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож, бүх шатны удирдлагын манлайллыг дээшлүүлэх, сургалтын чанарыг сайжруулж, албан хаагчдын мэдлэг ур чадварыг ахиулах, албаны шуурхай бэлэн байдлыг хангаж, сахилга, ёс зүйг төлөвшүүлэх”** гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

2.1. Удирдлага зохион байгуулалт болон 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар:

Шүүхийн шинжилгээний байгууллага нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тогтоол шийдвэр болон Хууль зүй, дотоод хэргийн Сайдын үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө, 2009 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Зарим цогцос оршуулах журам”, 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай”, 2010 оны 125 дугаар тогтоолоор батлагдсан “Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны дүрэмт хувцас хэрэглэх, цол олгох журам”, 2012 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтанд онцгой нөхцлийн нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилтийг тус тус ханган ажилласан байна.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 119 дүгээр тушаалаар баталсан “Криминалистикийн шинжилгээ хийх журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/215/421 дүгээр тушаалаар хамтран баталсан “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам”, А/216/422 дугаар тушаалаар баталсан “Гэмтлийн зэрэг тогтоох журам”, “Цогцост шинжилгээ хийх журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны А/114,14 дүгээр тушаалаар хамтран баталсан “Эдийн засгийн шинжилгээ хийх журам” болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллажээ.

Мөн тайлангийн хугацаанд захирлын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар “Ерөнхий эргүүлийн ажиллах журам”, 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар “Захирлын зөвлөлийн ажиллах журам”, А/15 дугаар тушаалаар “Албан хаагчдад мэргэжлийн зэрэг олгох журам”, 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/16 дугаар тушаалаар “Албан хаагчдын сургалтын

журам”, 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/23 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталж, хэрэгжилтийг хангах, бие бүрэлдэхүүнд сурталчлах зорилгоор байгууллагын цахим хаягт байршуулж, харьяа нэгжүүдэд албан бичгээр хүргүүлж мөрдлөг болгон ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн Сайдаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу “Шүүхийн шинжилгээний тухай хууль”-ийн төслийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх үнэлгээг хийлгэн тайланг хүлээн авч Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн болно. Ажлын хэсэг болон холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай нийт 29 удаа хуралдаж хуулийн төслийг хэлэлцэн, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу хуулийн үзэл баримтлал, үр дагаврын судалгааны тайлан, хуулийн төсөл, холбогдох материалыг Хууль зүй, дотоод хэргийн яамны холбогдох мэргэжилтнүүдэд тухай бүр хүргүүлэн ажилласан.

Улаанбаатар хотын зүүн талд Шүүх эмнэлгийн цогцос хадгалах барилга барих газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн газрын албаны дарга, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад санал, хүсэлтээ уламжлан ажиллаж байна. Барилгын зургийг “Зуун найм” ХХК-аар, барилга угсралтын төсвийг “Өрх” ХХК-аар хийлгүүлсэн байгаа болно.

“Шүүх шинжилгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр УИХ-ын Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэж, 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурлын хуралдаанд оруулсан болно. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу хуулийн төсөлтэй холбоотой баримт материалыг бүрдүүлэн өгч, ажлын хэсгийн хуралд тухай бүр оролцож байгаа бөгөөд хуулийг дагаж гарах дүрэм, журам, зааврын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж нийт 45 төсөл боловсруулж ажлын хэсгийн даргад танилцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу байгууллагын 2021 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж үнэлгээний тайланг холбогдох материалын хамт 2022 оны 01 дугаар сарын 10-ны өдөр 01/204 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн болно.

Дээрх үнэлгээний тайлангийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус байгууллагын эрсдэлийг үнэлэн зөвлөмжийг 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 1/1856 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд уг зөвлөмжийн дагуу төлөвлөгөөг

боловсруулан Хүрээлэнгийн захирлаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайланг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/3929 дугаартай албан бичгээр хүргүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангах 2022 оны төлөвлөгөөний тайлан, Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тайлан, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 1 дүгээр улирлын тайланг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр 02/1984 тоот албан бичгээр, эхний хагас жилийн тайланг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр 01/3923 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн болно. Нэгжийн дарга нар Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж байгаа бөгөөд үр дүн, биелэлтийг дүгнэж, тайланг тухай бүр ирүүлж хэвшсэн болно.

Мөн 2022 оны 1-9 дүгээр сарын үндсэн чиг үүргийн статистик мэдээ, инфографик мэдээ, үйл ажиллагааны тайлан, мэдээ, төлөвлөгөө болон бусад төлөвлөгөөний биелэлтийг гарган албан бичгээр болон цахимаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээг сар бүр цахим сангаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, ажиллажээ.


Хяналт-шинжилгээ, үнэлгээний
цахим сан
Mojha.unelgee.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

АЛСЫН ХАРАА - 2050

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН



- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар:

Шүүхийн шинжилгээний байгууллагаас “Гадаад харилцааны чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г боловсруулан 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр хүрээлэнгийн захирлын Б/121 тоот тушаалаар баталж мөн өдрийн 02/1620 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал:

БНСУ-ын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хүрээлэнгийн шинжилгээний лабораториудад засвар, үйлчилгээ хийх, стандартад нийцүүлэн шинэчлэн тоноглох, шинжилгээний лабораториудыг шинээр байгуулах, шинжээчдийг урт, богино хугацааны сургалтад хамруулах, БНСУ-ын шинжээч, мэргэжилтнүүдийг урьж сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Уг төслийн Техник эдийн засгийн үзүүлэлтийг “КОЙКА”-ийн судалгааны баг бүрэн хийж дуусгасан байна.

Тайлангийн хугацаанд “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, БНСУ-ын Шүүхийн шинжилгээний байгууллага болон тус хүрээлэнгийн холбогдох албан тушаалтнууд хамтран олон удаагийн цахим хурлыг зохион байгуулж холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд төслийн хүрээнд тус хүрээлэнгийн 10 удирдах албан тушаалтан

2022 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 04 дүгээр сарын 03-ны өдрүүдэд Сөүл хотод зохион байгуулсан эхний ээлжийн сургалтад хамрагджээ.

Мөн БНСУ-д зохион байгуулагдсан гүйцэтгэх албан тушаалтны эхний ээлжийн сургалтад тус хүрээлэнгийн ДНХ, Хими, Дижитал шинжилгээний 6 албан хаагч 2022 оны 08 дугаар сарын 01-нээс 09 дүгээр сарын 16-ны өдрүүдэд хамрагдсан. Хоёрдугаар ээлжийн сургалт 10 дугаар сарын 02-ноос 11 дүгээр сарын 16-ны хооронд зохион байгуулагдах бөгөөд ДНХ, Бичиг баримт, Химийн шинжилгээний лабораторийн 6 албан хаагчийг хамруулахаар ажилласан байна.

Тус хүрээлэнгийн Захирал болон гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн нар төслийн багийн гишүүдтэй 2022 оны 6 дугаар сарын 3-ны өдөр уулзалт хийж шинжилгээний лабораториудын засвар, тохижилтын ажил, сургалт, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн талаар ярилцсан бөгөөд засвар, тохижилтын ажлын тендер сонгон шалгаруулалтыг БНСУ-аас зарлан “Топэк инженеринг” ХХК шалгарч, холбогдох албан тушаалтнууд засвар хийгдэх 2, 5, 6 давхруудын зураг төсөл болон хүрээлэнгийн лабораториудтай 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр танилцсан байна.

Тус хүрээлэнгийн барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д нээлттэй зарлан 2022 оны 09 сарын 12-ны өдөр тендерийг нээж “Батдайчин” ХХК-ийг шалгаруулж хууль, эрх зүйн актын дагуу шалгарсан тухай мэдэгдлийг хүргүүлсэн байна.

БНСУ-ын Эксим банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Шүүх эмнэлгийн шинжилгээний лабораторийн болон цогцос хадгалах барилгыг Нийслэлийн баруун талд барихаар төлөвлөн ажиллаж Техник эдийн засгийн үзүүлэлтийг хийж дуусгажээ.

Барилга барих 1 га газрыг Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Архивын ерөнхий газрын баруун урд талд шийдвэрлүүлж, холбогдох техникийн нөхцөл, зөвшөөрлүүдийг авсан байгаа бөгөөд барилгын зургийг “Зуун найм” ХХК-аар, барилга угсралтын төсвийг “Өрх” ХХК-аар хийлгүүлсэн байна.

Төслийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/162 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр санал ирүүлсэн 3 компанийн материалаас сонгон шалгаруулалт хийж 2 компанийн материалыг БНСУ-ын Экзим банкинд хүргүүлсэн болно. Мөн төслийн техник эдийн засгийн үзүүлэлт, урилга бүхий 150 хуудас материалд дүн шинжилгээ хийж санал хүргүүлсэн байна.

Зураг төсөл, тендерийн баримт бичиг боловсруулах ажил 8 сарын хугацаанд хийгдэх бөгөөд 2023 оны 05 сард, барилга байгууламж барьж, тоног төхөөрөмж суурилуулах ажил 18 сарын хугацаанд хийхээр төлөвлөсөн бөгөөд төслийг нийт 3 жилийн хугацаанд хэрэгжүүлж 2025 оны 5 дугаар сард бүрэн дуусгахаар төлөвлөгдсөн байна.

Тус хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), профессор, цагдаагийн хурандаа Б.Болдбаатар “КОЙКА”-гийн Монгол дахь Суурин төлөөлөгч Ким Жүн Мутай “Монгол улсын шүүхийн шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн талаар 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр уулзалт хийж төслийн ажлыг эрчимжүүлэх талаар санал солилцон ажиллажээ.

БНСУ-ын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ДНХ-ийн шинжилгээний лабораторид “3500” генетик анализаторыг суурилуулах бөгөөд шаардлагатай урвалж бодисын асуудлыг шийдвэрлүүлснээр Митохондрийн ДНХ-ийн шинжилгээг хийх боломжтой болох бөгөөд Митохондрийн ДНХ-ийн шинжилгээний лаборатори байгуулахад шаардлагатай судалгааг хийж холбогдох арга зүйг боловсруулан Стандарт, хэмжил зүйн газраар /MNS 6718:2018/ стандартыг батлуулсан байна.

Америкийн Шүүхийн шинжилгээний академиас (AAFS) 2022 оны 02 дугаар сарын 21-нээс 25-ны өдрүүдэд АНУ-ын Вашингтон мужийн Сеатл хотод зохион байгуулсан 74 дэх удаагийн чуулга уулзалтад тус хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа Б.Болдбаатар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга П.Хадбаатар, ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн дэд захирал, цагдаагийн хошууч Г.Мөнгөншагай, Монгол улс дахь АНУ-ын Элчин сайдын яамны бүс нутгийн аюулгүй байдлын хэлтсийн ахлах ажилтан П.Даваажаргал болон тус хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын мэргэшсэн шинжээч, цагдаагийн ахмад Г.Оюунболд нарын хамт оролцсон байна.

Тус чуулга уулзалтад 50 гаруй орны 3000 гаруй эрдэмтэн судлаач, шинжээч нарын (хүн судлал, криминалистик, дижитал нотлох баримт судлал, эмгэг судлал ба биологи, шүд судлал, хор судлал, бичиг баримтын шинжилгээ, сэтгэцийн эмгэг судлал ба зан үйлдэл судлалын шинжлэх ухаан, инженер, физик, хими судлал, хууль эрх зүй) гэсэн үндсэн 11 салбар чиглэлээр хэлэлцүүлэг явагдаж 1200 орчим илтгэл хэлэлцэгджээ.

Чуулга уулзалтын эхний өдрүүдэд шүүх шинжилгээний чиглэлээр 21 төрлийн “Workshop” буюу онол практик хосолсон 5-8 цагийн төлбөртэй сургалт зохион байгуулагдсанаас “Бичиг судлалын шинжилгээг хийхэд тулгамдаж буй асуудал, гар бичмэл болон гарын үсэгт илрэх шинж тэмдгүүдийг хэрхэн үнэлж дүгнэлт өгөх” сэдэвт

сургалтад хамрагдсан бөгөөд Шүүхийн шинжилгээний академийн Бичиг судлалын лабораторийн захирал ноён Linton A. Mohammed-тай уулзаж цаашид хамтран ажиллах, хөгжингүй орны тэргүүн туршлага, шинэ арга аргачлалыг судлах чиглэлээр холбоо тогтоож ажилласан байна.

Түүнчлэн тус академийн гишүүн байгууллагаар элсэх хүсэлтээ уулзалтын үеэр бичгээр болон цахим хэлбэрээр албан ёсоор өгч АНУ-ын 50 муж болон дэлхийн 71 орны 6600 гаруй гишүүнтэй Америкийн Шүүхийн шинжилгээний академи (AAFS)-ийн гишүүн байгууллага болох эхлэл суурийг амжилттай тавьсан байна.

Мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулах, гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинжээч нарын ур чадварыг олон улсын түвшинд хүргэх, шинжилгээний шинэ төрлийн арга аргачлал, техник хэрэгслийн туршлагыг цаг алдалгүй судлах, цаашид үйл ажиллагаандаа нэвтрүүлж ашиглах зэрэг ихээхэн ач холбогдолтой хэд хэдэн зүйл дээр санал солилцсон бөгөөд цаашид тус академиас жил бүрийн 02 дугаар сард зохион байгуулагддаг чуулга уулзалтад оролцох, мөн үндсэн салбар бүрээс АНУ-д зохион байгуулагдах эрдэм шинжилгээний бага хуралд тус хүрээлэнгийн албан хаагчдыг оролцуулах талаар ярилцаж санал солилцсон байна.

Чуулга уулзалтын үед Америкийн Шүүхийн шинжилгээний академи (AAFS)-ийн Ерөнхийлөгч ноён Carl R. McClary-ын урилгаар ерөнхийлөгчийн нэрэмжит хүлээн авалтад оролцож олон орны Шинжилгээний байгууллагын удирдлага, төлөөлөгч, их дээд сургуулийн эрдэмтэн судлаач, шүүхийн шинжилгээ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг АНУ-ын болон Олон улсын холбоодын ерөнхийлөгч, удирдлагуудтай уулзаж цаашид хамтарч ажиллах талаар санал солилцжээ.

Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамны мөрдөн шалгах ажил хариуцсан Атташе Роберт Гуденкауф болон Монгол улс дахь АНУ-ын элчин сайдын яамны бүс нутгийн аюулгүй байдлын хэлтсийн ахлах ажилтан П.Даваажаргал нар Шүүхийн шинжилгээний удирдлагуудтай 2022 оны 04 сарын 15-ны өдөр уулзалт хийж Олон улсын хамтын ажиллагааны чиглэлээр харилцан ярилцсан бөгөөд уулзалтын танилцуулга болон техник, тоног төхөөрөмжүүдийн үнийн саналыг Хууль зүй, дотоод хэргийн Сайдад танилцуулсан байна.

Мөн БНСУ-ын Үндэсний цагдаагийн газрын Олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн төлөөлөгчид тус хүрээлэнгийн Тусгай шинжилгээний газрын лабораториудын үйл ажиллагаатай танилцан, хамтран ажиллах талаар санал солилцсон байна.

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн хууль сахиулах зөвлөх Грант Миллерээр ахлуулсан мэргэжилтнүүд тус хүрээлэнгийн шинээр байгуулагдсан Экологийн шинжилгээний лабораторийн үйл ажиллагаатай танилцаж, Олон Улсын

ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын туршлагыг нэвтрүүлэх, эрдэмтэд хоорондын харилцаа холбоог тогтоох, Экологийн шинжилгээний лабораторийг бэхжүүлэх, шинжээч мэргэжилтэн нарыг мэргэшүүлэх чиглэлээр санал солилцсон бөгөөд тус нийгэмлэгээс зохион байгуулсан “Зэрлэг амьтны хууль бус худалдаа”, Мэдээллийг төрөлжүүлэн үнэлэх” сэдэвт сургалтад Криминалистикийн шинжилгээний газрын Экологийн шинжилгээний лабораторийн шинжээчид хамрагдсан байна.

Интерпол (Олон улсын Эрүүгийн Цагдаагийн байгууллага)-оос 2021 оны 11 дүгээр сарын 01-нээс 2021 оны 12 дугаар сарын 23-ний өдрүүдэд зохион байгуулсан “INTERPOL DIGITAL FORENSICS PROGRAMME” олон улсын дижитал шинжилгээний эрхийн гэрчилгээтэй сургалтад тус хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын 2 албан хаагч цахимаар суралцаж 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр шалгалтыг өгч олон улсын сургалтын гэрчилгээ авсан байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Намьяанжу хотын “Эль” эмнэлгийн захирал, мэргэжилтнүүдийг 2022 оны 08 дугаар сарын 27-ны өдөр хүрээлэнгийн удирдлага хүлээн авч уулзан байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан байна. Энэхүү хамтын ажиллагаа нь байгууллагын алба хаагч, ажилтан, гэр бүлийн гишүүдэд хөнгөлөлттэй үнээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, сургалт, судалгаа, эрүүл мэндийн тусламж дэмжлэгтэй холбоотой хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх ач холбогдолтой арга хэмжээ болжээ.

Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Дэгү хотын Цагдаагийн ерөнхий газрын дарга болон тус газрын Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн нар 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр байгууллагын үйл ажиллагаатай танилцаж хамтран ажиллах талаар санал солилцсон байна.

Тус хүрээлэн нь Бүгд Найрамдах Солонгос Улсын Дэлхийн бие хамгаалах урлагийн холбоо"-ны удирдлагуудыг 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр хүлээн авч уулзан харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулжээ.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд М.П.Сингхтэйг Шүүхийн Шинжилгээний Үндэсний Хүрээлэнгийн захирал, доктор(Ph.D.), профессор, цагдаагийн хурандаа Б.Болдбаатар хүлээн авч уулзаж БНЭУ-ын Дотоод хэргийн яамны дэргэдэх Шүүхийн шинжилгээний удирдах газар болон Үндэсний шүүхийн шинжилгээний их сургуультай хамтын ажиллагааг хөгжүүлэх мөн хүрээлэнгийн албан хаагч, шинжээчдийг БНЭУ-д сургалтад хамруулах, лабораториудыг хөгжүүлэх, шинэчлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх талаар харилцан санал солилцжээ.

Шүүхийн шинжилгээний байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар

Шүүхийн шинжилгээний байгууллагын 2022 оны зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд харьяа нэгжүүдээс санал авч нэгтгэн, Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталж, харьяа нэгжүүдэд хүргүүлэн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулан ажилласан байна.

Байгууллагаас дэвшүүлсэн зорилт, үндсэн чиг үүргийн дагуу криминалистик, шүүх эмнэлэг, тусгай болон эдийн засгийн шинжилгээний чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Улсын хэмжээнд шинжээчид 2022 оны эхний 9 сарын байдлаар криминалистикийн 6877, шүүх эмнэлгийн 32671, тусгай шинжилгээний 14304, эдийн засгийн 100, нийт 53952 шинжилгээ хийж, дүгнэлт гарган, 26084 удаа хэргийн газрын үзлэгт оролцсон байна.

Үүнийг 2021 оны эхний 9 сартай харьцуулвал криминалистикийн 829 шинжилгээ буюу 13.7 хувь, шүүх эмнэлгийн 8328 шинжилгээ буюу 34.2 хувь, тусгай шинжилгээний 2603 шинжилгээ буюу 22.2 хувь, эдийн засгийн 12 шинжилгээ буюу 13.6 хувь, нийт 11772 шинжилгээгээр буюу 27.9 хувиар, хэргийн газрын үзлэг 6736 буюу 34.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1. Криминалистикийн шинжилгээний чиглэлээр:

Криминалистикийн шинжээчид 2022 оны 9 дүгээр сард: Мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны хүсэлтийн дагуу гарын мөрний 436, мөр судлалын 94, бичиг баримтын 33, галт зэвсгийн 17, дүр зургийн 3, дүрс бичлэгийн 13, авто техникийн 24, компьютер судлалын 13, дуу авианы 1, материал судлалын 2, бусад 1, нийт 417 шинжилгээ хийсэн байна. Төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 635, зөрчлийн 2 хэрэг байна. Мөн хүний амь нас хохирсон 399, хулгайн 597, дээрэмдэх 29, зам тээврийн ослын 350, бусад 522, нийт 1897 удаа хэргийн газрын үзлэгт оролцсон байна.

Хэргийн газрын үзлэгээр гарын мөр 1486, гутлын мөр 277, тээврийн хэрэгслийн мөр 330, бичил мөр 18, эвдлэгч багажийн мөр 109, биологийн гаралтай ул мөр 271, бусад ул мөр, эд мөрийн баримт 2467 илрүүлж, бэхжүүлэн авч шинжилгээгээр 51 эзэнгүй хэргийг нотолж, халуун мөрөөр нь 14 хэргийн холбогдогчийг тогтоосон байна.

Гарын мөрний “Адис-Папилон” ажлын станцын санг 861 мөр, 2236 дардсаар, галт зэвсгийн “Абис-Арсенал” санг 109 хонгио, 102 хошуугаар тус тус нөхөн баяжилт хийсэн байна.

2022 оны эхний 9 сарын өссөн дүнгээр: криминалистикийн шинжээчид мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны хүсэлтийн дагуу гарын мөрний 4166, мөр судлалын 1013, бичиг баримтын 560, галт зэвсгийн 599, тэсрэх төхөөрөмжийн 5, дүр зургийн 18, дүрс бичлэгийн 156, авто техникийн 180, компьютер судлалын 85, дуу авианы 14, материал судлалын 38, бусад шинжилгээ 43, нийт 6877 шинжилгээ хийсэн байна. Хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 6329, иргэний 229, захиргааны 40, зөрчлийн 285 хэрэг эзэлж байна.

Мөн хүний амь нас хохирсон 4561, хулгайн 6335, дээрэмдэх 367, зам тээврийн ослын 3597, бусад 6584, нийт 21444 удаа хэргийн газрын үзлэгт оролцсон байна.

Хэргийн газрын үзлэгээр гарын мөр 13684, гутлын мөр 3386, тээврийн хэрэгслийн мөр 3494, бичил мөр 61, эвдлэгч багажийн мөр 1264, биологийн гаралтай ул мөр 2811, бусад ул мөр, эд мөрийн баримт 28242 илрүүлж, бэхжүүлэн авч шинжилгээгээр 478 эзэнгүй хэргийг нотолж, халуун мөрөөр нь 117 хэргийн холбогдогчийг тогтоосон байна.

Гарын мөрний “Адис-Папилон” ажлын станцын санг 6996 мөр, 28281 дардсаар, галт зэвсгийн “Абис-Арсенал” санг 2638 хонгио, 2462 хошуугаар тус тус нөхөн баяжуулсан байна.

Үзлэг, шинжилгээний явц, байдлыг гэрэл зургаар бэхжүүлэн авч, өссөн дүнгээр хэргийн газрын үзлэгийн 285777, шинжилгээний 51031, цогцосны үзлэг, задлан шинжилгээний 88827, бусад 201313 нийт 626948 гэрэл зураг авч, үзлэг, шинжилгээний баримтад хавсаргасан байна.

2. Шүүх эмнэлгийн шинжилгээний чиглэлээр:

Шинжээч эмч нар 2022 оны 9 дүгээр сард: 417 удаа хэргийн газрын болон цогцосны үзлэгт оролцож, 418 цогцост задлан шинжилгээ, 2233 хүний биед гэмтлийн зэрэг тогтоох, 157 хүнд бэлгийн холбогдолтой үзлэг шинжилгээ, 4 нас тогтоох, 100 хавтаст хэргийн материалаар тус тус шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан байна.

Мөн эд эсийн 826 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан бөгөөд хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 1613, зөрчлийн 1300 хэрэг эзэлж байна.

2022 оны эхний 9 сарын байдлаар буюу өссөн дүнгээр: шинжээч эмч нар 4250 удаа хэргийн газрын болон цогцосны үзлэгт оролцож, 4268 цогцост задлан шинжилгээ, 4 эксгумац, 22767 хүнд гэмтлийн зэрэг тогтоох, 60 хүнд нас тогтоох, 1593 хүнд бэлгийн холбогдолтой үзлэг шинжилгээ, 1040 хавтаст хэргийн материалаар тус тус шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан байна.

Эд эсийн 2939 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан бөгөөд хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 26031, иргэний 28, зөрчлийн 3673 хэрэг эзэлж байна.

Засгийн газрын 2009 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Зарим цогцос оршуулах журам”-ын дагуу хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй 0-17 насны 23, 18 ба түүнээс дээш насны 24, ураг 17, араг яс 4 нийт 67 цогцосны оршуулах ажлыг хийж гүйцэтгэн, холбогдох мэдээллийг “Нэр хаяг тодорхойгүй, хариуцах эзэнгүй цогцосны мэдээллийн сан”-д оруулан бүрдүүлэлт хийж ажиллаж байна.

3. Тусгай шинжилгээний чиглэлээр:

Тусгай шинжилгээний шинжээчид 2022 оны 9 дүгээр сард: химийн 545, физикийн 8, биологийн 424, ДНХ-ээр эцэг тогтоох 28, ДНХ-ийн бусад 104, бактериологийн 105, нийт 1214 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан байна.

Хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 1164, иргэний 28, зөрчлийн 22 хэрэг эзэлж байна. Мөн хэргийн газрын үзлэгт 27 удаа оролцож, “ДНХ-ийн мэдээллийн сан”-г 59 мэдээллээр баяжуулсан байна.

2022 оны эхний 9 сарын байдлаар буюу өссөн дүнгээр: химийн 6305, физикийн 97, биологийн 5129, ДНХ-ээр эцэг тогтоох 438, ДНХ-ийн бусад 1252, бактериологийн 1083, нийт 14304 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан байна. Хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 13686, иргэний 438, зөрчлийн 180 хэрэг эзэлж байна. Мөн хэргийн газрын үзлэгт 390 удаа оролцож, “ДНХ-ийн мэдээллийн сан”-г 990 хүний мэдээллээр баяжуулсан байна.

4. Эдийн засгийн шинжилгээний чиглэлээр:

Эдийн засгийн шинжээчид 2022 оны 9 дүгээр сард: мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн дагуу 3 иргэн, 3 байгууллагад холбогдох хэрэгт 6 шинжилгээ хүлээн авч холбогдох өмчийн болон татварын маргаантай хавтаст хэрэг, санхүүгийн баримт материалд шинжилгээ хийж, 70,263,270 төгрөгийн хохирлын хэмжээ, шалтгааныг тогтоож, шинжээчийн дүгнэлт гаргасан байна.

2022 оны эхний 9 сарын байдлаар буюу өссөн дүнгээр: мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн дагуу 100 хэрэг хүлээн авснаас 25 аж ахуйн нэгж, байгууллага, 75 иргэнд холбогдох өмчийн болон татварын маргаантай хавтаст хэрэг, санхүүгийн баримт материалд шинжилгээ хийж, 2427,869,281 төгрөг, 932,495,668 валютын хохирлын хэмжээ, шалтгааныг тогтоож, шинжээчийн дүгнэлт гаргасан байна.

4. Бусад шинжилгээний лабораторийн ажлын хүрээнд:

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд

зөвлөлийн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга М.Отгонжаргал, Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгийн ажилтан С.Болорцэцэг, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн захирал У.Тунгалаг нарийн төлөөллүүд тус хүрээлэнгийн лабораториудын үйл ажиллагаатай 2022 оны 02 дугаар сарын 18-ний өдөр танилцаж, шинээр байгуулагдсан Экологийн шинжилгээний лабораторийг бэхжүүлэх, шинжээч мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх чиглэлээр болон цаашид хийх ажлын талаар санал солилцсон байна.

Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2020 оны А/216 дугаар тушаалаар Криминалистикийн шинжилгээний газрын харьяанд “Экологийн шинжилгээний лаборатори”-ийг шинээр байгуулж 6 шинжээчийг томилон ажиллуулж эхэлсэн бөгөөд мөн сайдын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар Экологийн шинжилгээний лабораторийн статусыг шинжилгээний бие даасан үндсэн нэгж болгон өөрчлөн зохион байгуулсан бөгөөд аймаг, орон нутаг бүсчлэн хариуцах 8 шинжээчийн орон тоог нэмэгдүүлсэн байна.

Тайлангийн хугацаанд экологийн шинжээч нар хэргийн газрын үзлэгт нийт 17 удаа оролцож шинжилгээний дээж, эд мөрийн баримт бэхжүүлэн авч, амьтан судлалын 20, мод судлалын 17, ургамал судлалын 3, нийт 40 шинжилгээ хийж, дүгнэлд гарган ажилласан байна.

Улсын хөрөнгө оруулалтын зардлаар Экологийн шинжилгээний лабораторид нийт 643.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 багцтай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах тендер зарлан ажиллаж байгаа бөгөөд Багц 2-т “Киа Моторс” ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдөр 167.0 сая төгрөгийн арын чингэлэг хэсгийн загварыг өөрчилж туулах чадварт нийцүүлэн тоноглогсон БНСУ-д үйлдвэрлэсэн “Киа Вонго 2700” маркийн автомашиныг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Дорнод, Ховд аймгийн Шүүхийн шинжилгээний албанд Эд эсийн шинжилгээний лабораторийг шинээр байгуулж үйл ажиллагааг нь жигдрүүлээд байна. Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын “Эд эсийн шинжилгээний лаборатори”-д иммуногистохимийн шинжилгээг нэвтрүүлсэн бөгөөд шинжилгээ хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийт 38.3 сая төгрөгөөр худалдан авч суурилуулжээ.

Мөн хүний нас барсан шалтгааныг шүүхийн шинжилгээгээр нарийвчлан тогтоох техник, тоног төхөөрөмжийг боловсронгуй болгох зорилгоор “Мехатроник” ХХК-тай 92.0 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж 2022 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт “Зөөврийн дижитал рентген аппарат”-ыг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.Тус газрын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор “4D хэт авиан шинжилгээний аппарат”, “Компьютерт томографын шинжилгээний аппарат”,

“Дижитал рентген шинжилгээний аппарат” худалдан авахад шаардлагатай төсвийг шийдвэрлүүлэхээр холбогдох газарт санал хүсэлт хүргүүлэн ажиллаж байна. Тусгай зориулалтын цогцос зөөвөрлөх автомашин худалдан авахаар 543.0 сая төгрөгийн тендер зарлан 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр “Киа Моторс” ХХК-тай 541.0 сая төгрөгийн гэрээг байгуулсан бөгөөд нийлүүлэлтийн шатандаа байна.

Мөн “Монтех дистрибьюшн” ХХК-тай 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр 44.2 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж 22 нэр төрлийн техник, тоног төхөөрөмж худалдан аваад байна. Мөн криминалистик, шүүх эмнэлэг, тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлэх, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлэх, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулах зорилгоор техник, тоног төхөөрөмжийн судалгааг хийж байгаа болно. Тус хүрээлэнгийн ДНХ-ийн шинжилгээний лабораторид өнөөдрийн байдлаар хорих ангид ял эдэлж буй хоригдол, өршөөлийн хуулиар суллагдсан ялтан, орон гэргүй тэнэмэл хүн, захиргааны хяналтад байгаа зэрэг нийт 17800 орчим хүний генетикийн дээж хадгалагдаж байна.

ДНХ-ийн лабораторид “NanoDrop-2000”, физикийн лабораторид “Shimadzu EDX” Рентген-Флуоресценцийн спектрометрийн багажийг худалдан авч шинжилгээнд ашиглах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Химийн шинжилгээний лабораторийн шинжээчид CHEM 40-CHEM 45 Microplate Reader багаж ашиглан цус, шээс, шүлсний дээжээс Метамфетамин тодорхойлох, цус, шээсний дээжнээс ЛСД /lysergic acid-LSD/ шинжилгээний арга зүйн заавар боловсруулан туршилт, судалгаа хийсэн байна.

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас хийсэн 2021 оны 12 дугаар сарын 07-ны №125 дугаартай худалдан, худалдан авах гэрээний дагуу нийт 17 төрлийн стандарт бодис хүлээн авахаас 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Эстони Улсаас ирсэн 5-fluoro MDMA-PICA /1mg/, MDMA-4en-PINACA /CRM/ /1ml/ нэртэй стандарт дээжийг Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газраас зохих бүрдүүлэлтийг хийн хүлээж авсан байна.

5. Шинжилгээтэй холбоотой бусад ажлын чиглэлээр:

“Олон Улсын Эмч нарын өдөр”-ийг тохиолдуулан Шүүх эмнэлгийн шинжилгээний газраас “ШҮҮХ АНАГААХ УХААН-ЭРДМИЙН ЧУУЛГАН 2022” зохион байгуулсан бөгөөд шүүхийн шинжилгээний байгууллагын төв орон нутгийн нийт шинжээч эмч нар болон Эмгэг Судлалын Үндэсний Төвийн эмгэг судлаач эмч нарыг оролцсон эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан. Хурлаар хэлэлцсэн эрдэм шинжилгээний 9 илтгэлээс шинжээч эмч Б.Энхжин, О.Болороо, Ш.Цэцэгмаа,

Г.Ханхүү, Б.Долгормаа, Г.Галиндэв, Б.Ариунзул нарын “Коронавирусын халдвартай нас барсан тохиолдлуудад хийгдсэн шүүх эмнэлгийн цогцос шинжилгээний тайлан судалгаа” сэдэвт илтгэл тэргүүн байр эзэлсэн байна.

Тусгай шинжилгээний газрын Бактериологийн шинжилгээний лабораторийн албан хаагч тэмбүү өвчин үүсгэгч “*terpanema pallidum*”-ийн гадаргуугийн молекул “TPPA” илрүүлэх өндөр чадвартай урвалжийн цомгийг ашиглан нийт 28 дээжинд холбогдох туршилт судалгааны ажил хийсэн байна. Эерэг гарсан хариуг “TP-ELISA-IG-G” ашиглан шинжлэхэд уг хариу батлагдаж бактериологийн лабораторид шинэ арга аргачлал нэвтрүүлсэн байна.

Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын Хан-Уул дүүргийн Криминалистикийн шинжилгээний тасгийн албан хаагчид 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр тус хүрээлэнгийн Гарын мөрийн шинжилгээний лабораториос зохион байгуулсан “Гарын мөр илрүүлж, бэхжүүлэхэд бүс нутгийн цаг уурын онцлогийг харгалзах нь” туршилт судалгаа, эрдэм шинжилгээний хуралд барзгар гадаргуутай хуванцар эдлэл, компьютер, арьсан эдлэл, хутга гэх мэт эд зүйл дээрээс хүйтэн нөхцөлд гэрэлд өдөөгддөг нунтгаар туршилт судалгаа хийж “ӨВӨЛ”-ийн улирлын туршилт судалгаанд тэргүүн байр эзэлсэн байна.

Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын дэд дарга, цагдаагийн хурандаа М.Чинбат нь Хууль зүй, дотоод хэргийн салбарын хэмжээнд тэсэрч дэлбэрэх эд зүйл, тэсэрч дэлбэрэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх таслан зогсоох, болзошгүй эрсдэлийг бууруулах чиглэлээр бичигдсэн анхны “Тэсэрч дэлбэрэх аюултай эд зүйл ба тэсрэлт дэлбэрэлтийн мөр” ном, гарын авлагыг хэвлүүлсэн байна.

6. Үйл ажиллагааг сурталчлах, нээлттэй ил тод байдлыг хангах талаар:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудас, Facebook хаяг, мэдээллийн самбарт байршуулан ажиллалаа. Үүнд:байгууллагын цахим сайтад 1, пэйж хуудасд 15, дотоод сүлжээнд 6 мэдээ, мэдээлэл байршуулжээ.

Байгууллагын цахим хуудсыг шинэчлэх ажил хийгдэж байгаа бөгөөд Нийтийн мэдээлийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байгууллагын байнгын нээлттэй байх мэдээллээс гадна байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр Facebook, E-Nifs хаяг, мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. Тухайлбал: Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн

хөтөлбөр” болон тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангах төлөвлөгөө, Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө, Хууль зүй, дотоод хэргийн сайд, хүрээлэнгийн Захирлын өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Мөн 2021 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ, албан хаагчдад олгогдсон цагдаагийн цол, шагнал, урамшуулал, 2022 оны батлагдсан төсвийн хуваарь, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын эрхэм зорилго, албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын хэмжээнд зохион байгуулсан сургалт, гадаад хамтын ажиллагаа, иргэд хүлээн авах цагийн хуваарь, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд, иргэдэд шинжилгээ хийлгэхтэй холбоотой зөвлөмж болон шүүх эмнэлгийн үзлэг, шинжилгээг хэрхэн яаж хийлгэх тухай танилцуулгыг шинэчлэн байршуулж, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл, зохион байгуулсан арга хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр байршуулж хэвшсэн болно.

Байгууллагын хэмжээнд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Хууль зүй, дотоод хэргийн Сайд болон Захирлын тушаал, дүрэм, журам, үүрэг даалгаврыг иргэд, олон нийт, албан хаагчдад мэдээлэх зорилгоор байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулж, сурталчилж байгаа бөгөөд байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байсан хүрээлэнгийн удирдлага, бичиг хэрэг болон өргөдөл, гомдол хүлээн авах ажилтны иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарийг 2022 оны 1 дүгээр сард шинэчилсэн байна.

Байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаар буюу “Шинжилгээ хийлгэхтэй холбоотой зөвлөмж”, “Иргэн гэмт халдлагад өртсөн, бие махбодид ямар нэг гэмтэл учирсан тохиолдолд тус хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хэрхэн яаж үзүүлэх, шинжилгээ хийлгэхэд шаардлагатай бичиг баримт” болон “Улсын хилээр нийтэд худалдах зорилгоор оруулж ирсэн иргэн, хуулийн этгээдийн галт зэвсгээр буудлага үйлдэж хонгио, хошууны дээж авч, санд бүртгэх үйлчилгээ”-ний талаар видео танилцуулгыг байгууллагын цахим хуудас, facebook, youtube цахим хуудсанд байршуулсан. Мөн дээрх үйлчилгээний мэдээллийг “E-khutuch.mn” цахим санд байршуулсан байна.

Шүүх эмнэлгийн шинжилгээний газраас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох зорилгоор “Нас барсан тухай А7 маягт” авах, “Шүүх эмнэлгийн амбулаторийн үзлэг, шинжилгээг хэрхэн хийлгэх” тухай зөвлөгөө,

тайлбар, мэдээллийг багтаасан “QR MENU” шинээр бий болгож үйл ажиллагаандаа нэвтрүүлжээ.

Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбогдож үйлчлүүлэгч иргэдийн мэдээллийг авч түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг худалдан авч 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системтэй бүрэн холбогдож, хурууны хээ уншигч “ZK-9500” төхөөрөмжийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан тохиргоо хийж Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын үзлэгийн өрөө, Бүртгэлийн хэлтэс, дүүргүүдийн криминалистикийн шинжилгээний хэлтэс, аймгийн Шүүхийн шинжилгээний албадуудад төхөөрөмжийг суурилуулсан байна.

Ийнхүү Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн сервертэй бүрэн холбож мэдээлэл татан авах кодыг бичиж төхөөрөмжүүдэд суулган ажиллагаанд оруулсан бөгөөд тус төхөөрөмжийг ашиглан тус байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн мэдээллийг түргэн шуурхай авч, хүндрэл чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж байна.

Цаашид цахим засаглалтай холбогдуулан “Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ хийлгэх цагийг цахимаар олгох”, “Галт зэвсгийн хонгио, хошууны бүртгэлийн цагийг цахимаар олгох”, “Салах ёс гүйцэтгэх цагийг цахимаар олгох”, “Шинжээчийн дүгнэлтийг цахим хэлбэрт шилжүүлж архивлах”, “Архивт хадгалагдаж буй баримт, материалыг цахим хэлбэрт шилжүүлэх” зэрэг ажлуудыг хийхээр холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөг батлан ажиллаж байгаа болно.

Байгууллагын үндсэн чиг үүрэг болон үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тухай бүр сурталчлан ажиллаж байна.

Тухайлбал:

-Хууль зүй, дотоод хэргийн салбарын төлөөлөл болсон 16-н мөрдөст бүсгүй оролцсон “Бид хэрхэн ажилладаг вэ?” сэдэвт уулзалт, ярилцлагад байгууллагын нэр бүхий албан хаагчдын төлөөлөл оролцсон бөгөөд мэдээллийн талаар UNREAD мэдээллийн сайтад 03 дугаар сарын 7-ны өдөр нийтлэгдсэн байна.

-Тагнуулын ерөнхий газраас зохион байгуулсан хэлэлцүүлэгт байгууллагын албан хаагчдын төлөөлөл оролцсон байна.

-Нийслэлийн прокурорын газар, Хар тамхитай тэмцэх газартай хамтарсан тулгамдаж байгаа асуудал хэрхэн шийдвэрлэх талаарх хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулан ажиллажээ.

-Формальдегид бодис түүний шинж чанар, хэрэглээ, хор хөнөөлийн талаар Тусгай шинжилгээний газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Ламчин ТВ-5 телевизэд ярилцлага, мэдээлэл өгсөн байна.

-Тус хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), профессор, цагдаагийн хурандаа Б.Болдбаатар, ШЭШГ-ийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч А.Амгаланболд, зөвлөх шинжээч эмч, цагдаагийн хошууч Д.Ганболд нар 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр “etv”, “ntv”, “25 tv” “itoim”, “tovch.mn”, “mass.mn”, “zarig.mn”, “ivoice.mn”, “mpa”, “parlament.mn”, “murch.mn”, “news.mn”, “eagle.mn” зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шинжилгээний чиглэлээр тайлбар хийжээ.

-Захиргаа, удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Ламчин 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр “Парламент” телевизэд “Урвалж бодис”-ийн хомсдлын талаар ярилцлага өгсөн байна.

6. Бүрэлдэхүүний сахилга, ёс зүйн талаар:

Тус байгууллагын нийт бие бүрэлдэхүүн Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2017 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан “Шүүхийн шинжилгээний байгууллагын албан хаагчийн сахилгын дүрэм”, Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, хүрээлэнгийн захирлын 2011 оны А/427 дугаар тушаалаар батлагдсан “Албаны шалгалт явуулах” журам, 2012 оны А/451 дугаартай “Иргэдээс Шүүхийн шинжилгээний байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авах шийдвэрлэх журам” болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.

Албаны шуурхай бэлэн байдлыг хангах, албан хаагчдын сахилга ёс зүйг өндөржүүлэх зорилгоор Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар болон Аймгийн шүүхийн шинжилгээний албаны дарга нар өдөр бүр 08.30 минутад хүрээлэнгийн шуурхай удирдлагын ахлах зохицуулагчид хоногийн “Гэмт хэргийн нөхцөл байдлын мэдээ”-г, мөн 16.00 минутад Аюулгүй байдал, дотоод хяналт, аудитын газарт нэгжийн “Сахилга ёс зүйн мэдээ”-г өгч хэвшил болгон ажиллаж байна.

Мөн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ, байгууллагын ил тод байдлын үнэлгээ гэсэн үзүүлэлтүүдийн хүрээнд тус тус хяналт шинжилгээ, үнэлгээний ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

Тус хүрээлэнгийн Аюулгүй байдал, дотоод хяналт, аудитын газар нь “Байгууллагын шалгалтын төлөвлөгөө, хуваарь”-ийг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хүрээлэнгийн Захирлаар батлуулсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хуваарийн дагуу холбогдох шалгалтын удирдамжийг батлуулж “Захиргаа, удирдлагын газар, Криминалистикийн шинжилгээний газар, Шүүх эмнэлгийн шинжилгээний газар, Шүүх шинжилгээний дүн бүртгэл, мэдээллийн газар, Эдийн засгийн шинжилгээний газар, Нийслэлийн Шүүхийн шинжилгээний газар, Тусгай шинжилгээний газар, Булган, Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Завхан, Сүхбаатар, Архангай, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Хэнтий аймгийн шүүхийн шинжилгээний албанд шалгалт хийж, холбогдох заавар, хугацаатай зөвлөмж өгч ажилласан байна.

Мөн батлагдсан хуваариас гадна хүрээлэнгийн Шүүх шинжилгээний дүн бүртгэл, мэдээллийн газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон холбогдох албан тушаалтнуудын хамт Баянхонгор, Өвөрхангай аймгуудад албан томилолтоор ажиллахдаа тухайн аймгийн Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагаатай газар дээр нь танилцан шалгаж үүрэг чиглэл өгсөн байна.

Байгууллага болон иргэдээс гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах 266342, 94124666 дугаарын утсыг тогтмол ажиллуулж байгаа бөгөөд хүрээлэнгийн 1, 2 дугаар байрны орох хэсэгт санал хүсэлтийн хайрцаг байршуулсан. Мөн бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг тус хүрээлэнгийн бичиг хэргийн ажилтан хүлээн авч, Захирлын цохолтоор холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд иргэдээс 171, албан хаагчдаас 272, албаны үйл ажиллагаа, албан хаагчийн сахилга, ёс зүй, шинжээчийн дүгнэлттэй холбоотой 24, нийт 467 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэн бөгөөд Аюулгүй байдал, дотоод хяналт, аудитын газар ирсэн өргөдлийн дагуу албаны шалгалт хийж, гомдол гаргасан иргэнд холбогдох хариуг өгсөн байна.

Байгууллагын хэмжээнд албаны үйл ажиллагаа, албан хаагчийн сахилга, ёс зүйтэй холбоотой 24 гомдол, мэдээлэл ирүүлснийг төрлөөр нь авч үзвэл иргэнээс бичгээр 21 гомдол, хууль хяналтын байгууллагаас бичгээр 2, бусад 1 мэдээлэл ирүүлсэн байна.

Монгол Улсын Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу Шүүхийн шинжилгээний байгууллагын (Төсвийн төвлөрүүлэн захирагч) харьяа 23 төсвийн байгууллагын шилэн дансны 2022 оны 1, 2 дугаар улирлын тайланг хүлээн авч нэгтгэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. Ийнхүү шилэн

дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 1633 мэдээллийг байршуулан олон нийтэд мэдээллэсэн ба хэрэгжилт 99 хувьтай байна.

Мөн хүрээлэнгийн газар, хэлтэс, албадын 2022 оны 2 дугаар улирлын эрсдэлийн үнэлгээний тайланг нэгтгэн 20 эрсдэлийг газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын холбогдох мэргэжилтэнд танилцуулан Хууль зүй дотоод хэргийн яамны <http://mojha.unelgee.gov.mn/>-д цахим системд оруулсан байна.

Үндэсний Аудитын Газар болон Орон нутгийн төрийн аудитын газраас Шүүхийн шинжилгээний байгууллагын (Төсвийн төвлөрүүлэн захирагчийн) харьяа 23 төсвийн байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийгдсэн сүүлийн 5 жилийн судалгааг нэгтгэн, дүгнэж Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн байна.

7. Сургалт, соён гэгээрүүлэх ажлын талаар:

Хүрээлэнгийн захирлын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/16 дугаар тушаалаар “Шүүхийн шинжилгээний байгууллагын албан хаагчдын сургалт, хөгжлийн журам”-ыг баталж, журмын дагуу албан хаагчдын боловсрол, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-г боловсруулан 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр баталж ерөнхий мэдлэг, хууль эрх зүйн чиглэлээр 9, удирдах албан тушаалтанд зориулсан 5, криминалистикийн чиглэлээр 8, шүүх эмнэлгийн чиглэлээр 7, тусгай шинжилгээний чиглэлээр 6, санхүү, эдийн засгийн чиглэлээр 4, гадаад хэлний чиглэлээр 3, ахлагч бүрэлдэхүүн үйлчилгээний ажилтнуудад зориулсан 4, амьдралын зөв дадал хэвшил 7, нийт 53 удаагийн сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулжээ.

Гурав. Санхүү, хөрөнгө оруулалт болон хангалт,
үйлчилгээний талаар

Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажилласан бөгөөд 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг гарган Сангийн яамны “Э-тайлан” -ийн системд байршуулсан байна.

Байгууллагын 2021 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд гаргаж 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 01/457 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн бөгөөд аудитын шалгалт хийгдэж 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/713 тоот албан бичгээр “Зөрчилгүй” дүгнэлт авч ажилласан байна.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь 2022 онд жилийн 15,037,383.7 төгрөгийг улсын төсвөөс санхүүжих төлөвлөгөөтэйгөөр ажиллаж эхэлсэн бөгөөд эхний 8 сарын байдлаар 10,512,853,200.0 төгрөгийг улсын төсвөөс санхүүжиж

10,517,044.300.0 төгрөг буюу 100.3 хувийн гүйцэтгэлтэй, үндсэн үйл ажиллагааны орлого 456,822.000 төгрөг төлөвлөгдсөнөөс 670,055,732.38 төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлж 146.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан, 2022 оны батлагдсан төсөв, 2022 оны эхний 8 сарын төсвийн гүйцэтгэл болон бусад тайлан, мэдээг Монгол Улсын төсвийн ил тод байдлын www.shilendans.gov.mn, байгууллагын www.nifs.gov.mn цахим хуудсанд байршуулж, нийт бие бүрэлдэхүүнд мэдээлсэн болно. Мөн 2022 оны 1-8 дугаар сарын мэдээг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг бүрдүүлээд байна.

Албан хаагчдын 2022 оны 1-8 дугаар сарын цалин хөлсийг хугацаанд нь бодож олгосон бөгөөд Нийслэлийн татварын газарт 213.2 сая төгрөг, ЧД-ийн НДХэлтэст 153.5 сая төгрөгийг тушааж, тайлан, мэдээг хуулийн хугацаанд гарган хүргүүлж өр төлбөргүй ажиллалаа.

Тус хүрээлэнгийн Санхүү төлөвлөлт, хангамжийн газар, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар болон Аймгийн шүүхийн шинжилгээний албадууд Төрийн хэмнэлтийн тухай хууль, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг холбогдох тооцоо, судалгаа, тоо баримт, шаардлагатай тайлан, мэдээ хөтөлбөр, арга хэмжээнд тулгуурлан боловсруулж хуулийн хугацаанд 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдөр 01/4743 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/115,176,142 дугаар тушаалаар батлагдсан “Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/114,14 дүгээр тушаалаар батлагдсан “Эдийн засгийн шинжилгээ хийх журам”-ын дагуу төлбөрийг тухай бүрт нь Төрийн сангийн дансанд тушааж, 2022 оны эхний 5 сарын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө нь 111.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс одоогийн байдлаар Төрийн санд 670.0 сая төгрөгийн орлогыг Улсын төсөвт тушаасан байна.

Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/250 дугаар тушаалаар батлуулсан. Үүнд Хөрөнгө оруулалтын зардлаар: Экологийн шинжилгээний лабораторийн багаж техник хэрэгсэл 643.0 сая төгрөг, лабораторийн барилга 2,100.0 сая төгрөг, тусгай зориулалтын цогцос зөөвөрлөх автомашин 543.0 сая төгрөг, урсгал зардлаар: Нормын хувцас 622.5 сая төгрөг, эм урвалж 650.0 сая төгрөг, техник хэрэгсэл болон багаж 598.2 сая төгрөг, тээвэр шатахуун 120.3 сая төгрөг, бичиг хэрэг 39.7 сая төгрөг

тус тус батлагдсан болно. Худалдан авалтын тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, /www.tender.gov.mn/, шилэн данс болон өдөр тутмын сонин хэвлэлд тогтмол байршуулан ажилласан байна.

Мөн Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ойлгомжтой, бодитой, үнэн зөв, тогтоосон хугацаанд байршуулан ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Тусгай шинжилгээний газрын Физикийн шинжилгээний лабораторид натригаас уран хүртэлх химийн элементийг тодорхойлдог нэг удаад 16 дээж хэмжих хүчин чадалтай “EDX-7200” маркийн рентген флуоресценцийн спектрометр тоног төхөөрөмжийг 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр худалдан авч суурилуулан шинжилгээ хийж эхлээд байна.

Мөн Криминалистикийн шинжилгээний газрын Мөр судлалын шинжилгээний лабораторид “Schott KL2500” маркийн нэг чигийн уян гэрэл, бүх төрлийн гэрэл зургийн аппаратыг “AmScope”, “XTL” маркийн микроскопын дурантай холбох хэрэгсэл болох (тупснууд)-ийг худалдан авах гэрээг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр “Монтех” ХХК-тай байгуулан ажиллаж 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр тоног төхөөрөмжийг, Бичиг баримтын шинжилгээний лабораторид “HP Scanjet Pro 2500 f1 Flatbed” маркийн скайнер, “Multinational portable fake paper detector” маркийн зөөврийн хэт ягаан туяаны гэрэл болон нэвт гэрэл, “NTEUMMI:G500T” маркийн зөөврийн скайнер худалдан авах гэрээг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр “Монтех” ХХК-тай байгуулан ажиллаж 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр тоног төхөөрөмжийг тус тус хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

-Тусгай шинжилгээний газарт “Elisa-ADX-110” багаж, бэлгийн замын халдварт өвчин болох хламидыг илрүүлэх оношлуур, урвалж бодисыг 20.7 сая төгрөгөөр худалдан авч суурилуулан хламидын халдварыг илрүүлэх шинжилгээг хийж эхэлсэн ба өнөөдрийн байдлаар нийт 238 хүний дээжид шинжилгээ хийгээд байна. Мөн ДНХ-ийн шинжилгээний чанар, үр дүнг дээшлүүлэх, нэвтрүүлэхэд шаардлагатай нийт 320.0 сая төгрөгийн урвалж бодис худалдан авсан бөгөөд үүний үр дүнд эмэгтэй хүүхдийг эцэгтэй нь харьцуулах шинжилгээг хийх боломжтой болсон.

Мөн тус газрын Биологийн шинжилгээний лабораторид ГХУСА33-ийн санхүүжилтээр “Olympus” DX-53 маркийн 3 ширхэг микроскопыг худалдан авч шинжилгээ хийж байна.

Дүрэмт хувцас нийлүүлэх нийт 11 багцтай 418.2 сая төгрөгийн гэрээг 7 аж ахуйн нэгжтэй байгуулан ажиллаж 14 нэр төрлийн цагдаагийн дүрэмт хувцсыг хүлээн авч 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн албан хаагчдад бүртгэлээр олгосон болно.

Мөн “Саммит” ХХК-тай 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр 148.8 сая төгрөгийн 58 ширхэг дижитал зургийн аппарат нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж 2022 оны 09 дүгээр сард хүлээн авч албан хаагчдад бүртгэлээр олгосон болно.

Монголын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан хүрээлэнгийн захирлын 2022 оны Б/37 тоот тушаалаар тус байгууллагын ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлж 6.2 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.

Байгууллагын өмч хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах зорилгоор 2022 оны А/12 дугаар тушаалаар тус хүрээлэнгийн өмч хамгаалах зөвлөлийг байгуулан ажиллаж байна.

Байгууллагын төв байрны дээврийн урсгал засварт 36.6 сая төгрөг, 3 болон 4 давхрын өрөөнүүдийн хаалгыг сольж хурлын заалыг засварлах ажилд 13.1 сая төгрөг, гадна талбайн хашаа болон замын хашлага /боржур/, зогсоолын тэмдэглэгээ зэргийг будаж өнгө үзэмжийг сайжруулах ажилд 1.2 сая төгрөг, бялдаржуулах өрөөг засварлаж тохижуулах ажилд 8.0 сая төгрөг, 102 тоот өрөөг засварлах ажилд 0.3 сая төгрөг, 307 болон 302 тоот өрөөнүүдэд алба хаагчдын хувцасны шүүгээг шинээр хийх ажилд 3.2 сая төгрөг, В1 давхрын коридорын шаланд плита нааж засварлахад 0.7 сая төгрөг, туршилтын буудлагын өрөөг засварлахад 0.2 сая төгрөг, байгууллагын эргэн тойрон, гадна талбайн гэрэлтүүлгийг шинээр хийх ажилд 2.2 сая төгрөгийг, Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын Нэг цэгийн үйлчилгээний төвийн засвар, тохижилтод 8.9 сая төгрөгийг, Шүүх эмнэлгийн ариун цэврийн өрөөний агааржуулалтын системийг шинээр суурилуулах ажилд 0.8 сая төгрөг, Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын 1 давхарт иргэдийн хүлээлгийн танхимд 1.2 сая төгрөгийн үнэ бүхий нийт 4 ширхэг сандлыг байршуулсан. Мөн Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын барилгын гадна талыг сэргээн засварлахад 2.2 сая төгрөг, байрны 1400 метр квадрат дээврийн засварын ажилд 90.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан болно.

Тайлангийн хугацаанд дуудлагын автомашинуудад нийт 12.9 сая төгрөгийн засвар, үйлчилгээ хийж шуурхай бэлэн байдлыг хангасан бөгөөд одоогоор гарсан ямар нэг эвдрэл гэмтэл байхгүй, хэвийн ажиллаж байгаа болно.

Мөн шинжилгээний лабораториудын техник, тоног төхөөрөмжид гарсан эвдрэл гэмтлийг 6.2 сая төгрөгөөр засвар хийсэн.

Криминалистикийн шинжилгээний газрын Авто техникийн шинжилгээний лабораторид дотоод нөөц бололцоондоо тулгуурлан 484,000 төгрөгийн будгийн ажил

хийж, дугуй задлагч багаж, тоног төхөөрөмжид урсгал засвар буюу обуд хавчигчийн хуванцар хийн хуваарилагчийг сольж, тосолгоо үйлчилгээ хийсэн. Мөн лабораторийн дотор талд цэвэрлэгээ хийж, өргүүр, хийн хураагуурт тосолгоо, чангалгаа, сэрээт ачигчийн хөдөлгүүрийн тосыг солих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мөн газрын Галт зэвсгийн шинжилгээний лабораторид хонгио, хошуу хадгалах сейф, цаасан хайрцаг худалдан авч байршуулсан бөгөөд В1 давхрын туршилтын буудлагын өрөөнд 5.6 сая төгрөгийн засвар хийж тохижуулан, дуу чимээ тусгаарлах хавтанг шинээр хийж, бууны тавиур хийж байршуулсан болно.

Баян-Өлгий аймгийн Шүүхийн шинжилгээний албанд 2,100.0 сая төгрөгөөр, Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний албанд 200.0 сая төгрөгөөр лабораторийн барилга барихаар тус тус тусгасан бөгөөд Баян-Өлгий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зарлаж, 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр нээж үнэлгээ хийсэн боловч тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангасан нэг ч тендер ирүүлээгүй тул 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр дахин зарласан болно. Тус тендер шалгаруулалтыг 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр нээж үнэлгээг хийж “Өлке Констракшн” ХХК шалгарсан боловч “Агайын” ХХК гомдол гаргасан.

Уг гомдлын дагуу АТГ-аас шалгалтын ажиллагааг явуулсан бөгөөд Нийслэлийн прокурорын газрын “Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах тухай” 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 369 дүгээр тогтоолоор хууль зөрчсөн гэх үндэслэл байхгүй байна гэсэн шийдвэр гарсан болно. Өнөөдрийн байдлаар барилгын суурийн цутгалтын ажлыг бүрэн хийж, зоорийн давхрын хана, баганы арматур боогдсон бөгөөд хэв хашмалын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Мөн Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэчийг сонгон шалгаруулах эрхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/285 дугаар тушаалаар Сэлэнгэ аймгийн Засаг даргад шилжүүлсэн болно. Тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны цахим системд 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зарлаж 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр нээсэн боловч нэг ч оролцогч байхгүй шалтгаанаар тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул “Сэлэнгэ таван хан” ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр шууд гэрээ байгуулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар газар шорооны ажил, суурийн ажил, гадна дотор ханын өрлөгийн ажил, бүс бетон, дотор цахилгааны монтажны ажлууд хийгдэж дууссан байна.

Мөн Архангай, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Төв, Увс, Ховд аймгийн шинжилгээний албадуудад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар лабораторийн барилга барих санал боловсруулан 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр 01/2431 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн болно.

Байгууллагын 2020 оны Шилэн дансны тайлан нэгтгэлийг заагдсан тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн бөгөөд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хуульд заасан хугацааны дагуу холбогдох мэдээллийг байгууллагын цахим хаягт тухай бүр байршуулан ажилласан. 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 1.365.1 сая төгрөгийн гүйлгээ хийж хуулийн хугацаанд байршуулан ажилласан.

Шинжилгээний лабораториудад 650.0 сая төгрөгийн урвалж бодис, оношлуур, бараа материал болон лабораторийн туслах материал худалдан авахаар 8 багцтай тендер зарлан ажиллаж шаардлагатай урвалж бодисыг хүлээн авсан байна. Тухайлбал:

Химийн шинжилгээний лабораторид 40.0, ДНХ-ийн шинжилгээний лабораторид 399.0, Биологийн шинжилгээний лабораторид 60.0, Бактериологийн шинжилгээний лабораторид 20.0 сая төгрөгийн урвалж бодис, шил сав, сэлбэг хэрэгсэл худалдан авч ашиглаж байна.

Албан хаагч тэдгээрийн ар гэр болон ахмад ажилчдад нийт 11.7 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 17 албан хаагчид 801.2 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна. Түүнчлэн 78.1 сая төгрөгийн нэг удаагийн хөдөлмөр хамгааллын хэрэглэл худалдан авч, албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангажээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын Өвөрхангай, Баянхонгор аймгуудад ажилласан ажлын хэсэгт Шүүх шинжилгээний дүн бүртгэл, мэдээллийн газрын дарга, цагдаагийн хурандаа Д.Мөнхбат ажиллаж ажилтан, албан хаагчийн ажиллах нөхцөлийг сайжруулах үүднээс Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албанд иж бүрэн компьютер 2 ш, Өвөрхангай аймгийн Шүүхийн шинжилгээний албанд иж бүрэн компьютер 3 ш, мөн дээрх албадад тус бүр иж бүрэн 5 ханатай гэр бэлэглэсэн байна.

Мөн Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албанд 2 ширхэг иж бүрэн компьютер, 1 ширхэг нөүтбүүк, Төв болон Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албанд иж бүрэн компьютер 1 ширхэг, принтер 1 ширхэг, Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний албанд иж бүрэн компьютер 1 ширхэг, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газарт иж бүрэн компьютер 1 ширхэг, Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн албан хаагчдад 28 ш иж бүрэн компьютерыг тус тус анхан шатны баримтаар олгож ажилласан байна.

Аймгийн шүүхийн шинжилгээний албадууд материаллаг баазаа бэхжүүлэх зорилгоор албаны орон сууц болон сүүлийн үеийн дэвшилтэд техник, тоног төхөөрөмжөөр хангах талаар аймгийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудад танилцуулж санал хүсэлт танилцуулан дараах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шийдвэрлүүлсэн байна. Тухайлбал:

Мөн Баянхонгор, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгийн шүүхийн шинжилгээний албадууд аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга болон ГХУСАЗСЗөвлөлд экологийн шинжээчийн үйл ажиллагаанд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр жагсаалт, үнийн дүнгийн задаргааг хүргүүлсэн байна.

-Баян-Өлгий аймгийн шүүхийн шинжилгээний алба аймгийн Засаг даргын мнөөц хөрөнгөнөөс 4.2 сая төгрөгийг шийдвэрлүүлж хэргийн газрын үзлэг хийхэд шаардлагатай дрон, гэрэлтүүлэг, асар худалдан авсан байна.

-Булган аймгийн шүүхийн шинжилгээний алба аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх “Шинэ хөгжлийн зам мөрийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 60.0 сая төгрөгийн 2 өрөө орон сууц худалдан авах арга хэмжээг тусгуулан ажиллаж “Гурван уулын хишиг” ХХК-тай гэрээ байгуулж 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдөр Булган аймгийн Булган сумын 5-р баг, 11-р байрны 6 тоотод 42 метр квадрат 2 өрөө орон сууц худалдан авсан байна.

-Говьсүмбэр аймгийн шүүхийн шинжилгээний алба аймгийн төсвөөс 28.5 сая төгрөг шийдвэрлүүлж шүүх эмнэлгийн шинжилгээний микротом багаж худалдан авсан байна.

-Дархан-Уул аймгийн шүүхийн шинжилгээний алба аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 9.5 сая төгрөгийг шийдвэрлүүлж эд эсийн шинжилгээнд ашиглах микроскоп худалдан авсан байна.

-Дорноговь аймгийн шүүхийн шинжилгээний албанд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 3.5 сая төгрөг шийдвэрлэж өгсөн бөгөөд албанд шаардлагатай байсан техник, хэрэгсэл, эд хогшил худалдан авсан байна.

-Дорнод аймгийн шүүхийн шинжилгээний алба аймгийн Засаг даргад хүсэлт хүргүүлж экологийн шинжээчид шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 42.440.000 төгрөгийг шийдвэрлүүлсэн байна.

-Орхон аймгийн шүүхийн шинжилгээний алба Аймгийн засаг даргатай байгуулсан гэрээнд туулах чадвар сайтай цогцос зөөвөрлөх буюу хэргийн газрын үзлэгт оролцох боломжтой автомашин худалдан авах арга хэмжээг тусгуулан ажиллаж 2017 онд БНСУ-д үйлдвэрлэгдсэн 2 ширхэг “Хьюндай Старекс TQ” маркийн

автомашиныг 130.0 сая төгрөгөөр худалдан авч албаны шуурхай бэлэн байдлыг хангасан байна.

-Сэлэнгэ аймгийн шүүхийн шинжилгээний албанд аймгийн ГХУСАЗСЗөвлөлөөс төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 3.5 сая төгрөгөөр хэргийн газрын үзлэгийн дрон төхөөрөмжийг худалдан авч өгсөн байна.

-Хөвсгөл аймгийн шүүхийн шинжилгээний алба аймгийн Засаг даргад хүсэлт тавьж 1.5 сая төгрөгийг шийдвэрлүүлэн электрон жин худалдан авсан байна.

-Хэнтий аймгийн шүүхийн шинжилгээний алба аймгийн ГХУСАЗСЗөвлөлөөс 3.0 сая төгрөгийг шийдвэрлүүлж принтер, зургийн аппарат зэргийг худалдан авч албаны материаллаг баазыг ханган ажилласан байна.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь тайлант хугацаанд байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгон үйл ажиллагааг цахимжуулж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөлийг сайжруулах, удирдлагын манлайллыг дээшлүүлэхэд түлхүү анхаарч хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ бүрэн биелүүлэн ажилласан байна.

2.2. ШШҮХ-ийн бодлого, үйл ажиллагааны сэтгэл ханамжийн үнэлгээ

Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд 367 он хамрагдсанаас 12 анкет хүчингүй болж 355 иргэн хамрагдсан. Үүний 61% нь эмэгтэй, 39% нь эрэгтэй, насны бүлгээр харвал 11% нь 18-25 настай, 25% нь 26-35 настай, 36% нь 36-45 настай, 29% нь 46-аас дээш настай иргэд байна. Боловсролын хувьд 78% нь дээд, 13% нь бүрэн дунд, 4% нь техник болон мэргэжлийн дунд (МСҮТ), 3% суурь /8,9 анги/ боловсролтой, үлдсэн 2% нь боловсролгүй/бага гэсэн ангилалд хамаарагдаж байна.

Ажил эрхлэлтийн байдлыг харвал 90% ажил хөдөлмөр хийдэг, үүний 40% нь төрийн байгууллагад ажилладаг ба ажилгүй иргэд 8%-ийг эзэлж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагатай хамтран ажилладаг байгууллагын бодлого, үйл ажиллагаа, чиг үүрэг, гүйцэтгэл, хэрэгжилтийн үнэлгээ, үр дүнг 1-5 (1 бол маш муу, 5 бол маш сайн) оноогоор үнэлж, дундаж үзүүлэлтийг 3 байна гэж тооцсон.

Иргэдээс авсан судалгааны дүнг харвал үүргийн хэрэгжилтийн үр дүнд өгсөн үнэлгээ өмнөх оноос өссөн байна. Тухайлбал үйлчилгээний түргэн шуурхай байдлын дундаж үзүүлэлт 2.8- аас 2.9, хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийн дундаж үзүүлэлт 2.8-аас 3.0 болж тус тус өссөн дүн гарлаа.

Харин Шүүхийн шинжилгээний байгууллага болон хуульчдын зүгээс өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ иргэдээс өндөр байгаа нь салбарын мэдээлэлд илүү, ойр байдагтай холбон авч үзэж болох юм.

Хүснэгт 7. Иргэд оршин байгаа газраа хэр аюулгүй, амгалан тайван байгаа байдал, үйлчилгээний түргэн шуурхай байдал, хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийг харуулбал:

Үзүүлэлт	2021	2022
1. Тайван байдал	3.0	3.0
2. Үйлчилгээний түргэн шуурхай байдлын дундаж үзүүлэлт	2.8	2.9
3. Хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийн дундаж үзүүлэлт	2.8	3.0

Зураг 5. Судалгааны үзүүлэлт



Шүүхийн шинжилгээний байгууллагын үндсэн үйл ажиллагаа, хамтын ажиллагаатай байгууллагын үйл ажиллагаа, мэдээлэл, иргэдийн аюулгүй, шударга байдлыг 1-5 оноогоор (1 бол маш муу, 5 бол маш сайн) үнэлүүлсэн.

Шүүхийн шинжилгээний байгууллагын үндсэн үйл ажиллагааны судалгаанд хамрагдсан иргэдийн 13% нь мэдэхгүй байна. Үндсэн үйл ажиллагаа, үүргийн талаар мэдэж байгаа иргэдийн сэтгэл ханамжтай байдлын түвшин дундаж хэмжээнд хүрэх хандлагатай байна. Аливаа төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд сэтгэл хангалуун биш, төрд итгэх итгэл суларсан нь дүнд нөлөөлсөн байж болох учир энэ асуудлыг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзэв.

Хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн буурсан үзүүлэлттэй гарсан боловч мэдэхгүй гэх хариулт 2021 онд иргэдийн 8-11%ийг эзэлж байсан бол 2022 онд 6-7% болж буурсан эерэг үзүүлэлттэй гарав.

Энэ хүрээнд тус байгууллагын үүргүүдийг иргэд 2.4-2.8 оноогоор үнэлсэн бол хамтран ажилладаг байгууллагын алба хаагчид болон хуульчид иргэдээс арай илүүгээр буюу 2.8-2.9 оноогоор үнэлжээ.


Хүснэгт 8. Үзүүлэлтийг харуулбал:

	Үзүүлэлт	Иргэд	ТАХ, хуульчид
1	Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны залгамж холбоо	2.5	2.8
2	Ирсэн санал гомдолд хариу өгөх байдал	2.7	2.9
3	Ажилтан, алба хаагчдын харилцаа хандлага	2.7	2.9
4	Үйл ажиллагааны шуурхай байдал	2.6	2.8
5	Авилгаас ангид, шударга байдал	2.4	2.8
6	Үйл ажиллагаандаа техник технологийн дэвшил ашиглах байдал	2.8	2.9
7	Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ холбогдох хүмүүст мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх байдал	2.7	2.8
8	Хяналт үнэлгээ хийх байдал	2.6	2.9


Авилгаас ангид, шударга ажиллаж байгаа (2.4), байгууллагын үйл ажиллагааны залгамж холбоог (2.5) үнэлж, техник технологийн дэвшил ашиглах байдалд иргэд, төрийн алба хаагч, хуульчид өндөр үнэлгээ өгсөн байна.

Төрийн байгууллагаас бүрэн үйлчилгээ авсан байдал, хэдэн байгууллага дамжсан болох

Зураг 9.



Зураг 10




Судалгаанд оролцсон иргэдээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчийн ёс зүйн байдлыг 1-5 оноогоор (1 бол маш муу, 5 бол маш сайн) үнэлүүлж, дундаж үзүүлэлт 3 байхаар тооцож, үр дүнг дундаж үзүүлэлттэй харьцуулсан байдлаар гаргалаа.

Хүснэгт 9. Иргэд Шүүхийн шинжилгээний байгууллагаар үйлчлүүлсэн байдалд өгсөн үнэлгээ

Хэмжүүр	Үзүүлэлт	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
Чанар	Үйлчилгээний чанар	7	13	38	39	4
	Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчид асуудлыг нэг удаагийн	10	17	40	29	4

	хандалтаар шийдэж өгөхийг хичээдэг байдал					
	Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, мэдлэг	9	15	36	34	5
	Хариу мэдээлдэг байдал	13	18	37	24	8
	Санал, гомдол илэрхийлэх боломж нээлттэй байдал	11	21	34	28	6
Хүртээмж	Байгууллагын хүртээмжийг үнэлсэн байдал	6	12	45	33	4
	Ачаалал, хэвийнн байдал	6	13	45	32	4
	Үйлчилгээг хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх талаар энгийн, ойлгомжтой байдал	5	18	37	34	6
	Холбогдох үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай, ил тод байдал /самбар гэх мэт/	6	18	42	28	5
	Хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөөг авах боломжтой байдал	6	16	41	32	5
Харилцаа, ёс зүй	Тус байгууллагын алба хаагчийн харилцаа, хандлага	6	15	36	35	8
	Ажилтнууд надад туслахад бэлэн байдаг	8	14	39	32	7
	Ажилтнуудын эелдэг таатай харилцаа	8	13	39	33	8
	Бүх үйлчлүүлэгчтэй эрх тэгш харилцах байдал	8	15	38	32	6
	Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал	8	10	43	31	8
	Цаг баримтлах, ашиглах байдал	8	16	37	31	9
	Шударга байдал /гар харах гэх мэт/	7	13	40	32	9
Орчин нөхцөл	Тус байгууллагын орчин нөхцөл	3	12	43	36	6
	Байгууллагын гадна, доторх тэмдэг, тэмдэглэгээ харагдахуйц ойлгомжтой байдал	3	13	44	33	6
	Байгууллагын доторх үзгэн бал, маягт гэх мэт туслах зүйлсийн хүрэлцээ	3	16	43	32	7
	Хүлээлгийн танхим дахь ширээ сандлын хүрэлцээ	3	16	43	32	7
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал	12	26	34	21	7

Зураг 6.Үйлчилгээний хүртээмж, орчин нөхцөл



Иргэд төрийн үйлчилгээ, чанар хүртээмжийг сайнаар дүгнэсэн байна. Үйлчилгээ авсан иргэдийн үнэлэмж өссөн боловч төрийн үйлчилгээний чанар хүрээмж, өмнөх жилтэй харьцуулахад хэр ахицтай байгааг NPScore үнэлгээний аргачлалаар тооцож үзсэн болно.

2021 онтой харьцуулахад 2022 онд гарсан ахиц дэвшил нь үйл ажиллагаа, үйлчилгээ сайжирсан, тус байгууллага нь үйл ажиллагаандаа техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж байгаа, Шүүхийн шинжилгээний байгууллагатай хамтын ажиллагаатай байгууллагын алба хаагчдын харилцаа, хандлага сайжирсан, орчны тав тухтай байдал дээшилсэн тохилог болсон гэж иргэд үзсэн байна.

2.3. ШШҮХ-ийн үйлчилгээний чанар, хүртээмжийн чанар


Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6-10 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг тогтоох шалгуур үзүүлэлт”-ийн дагуу Шүүхийн шинжилгээний байгууллагын ил тод байдлын үнэлгээг хийхэд байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион

байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байх үзүүлэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас үнэлсэн байдлаар бид тайланд тусгалаа.

№	Байгууллага	Ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ		Харьцуулалт
		2021	2022	
1	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн	100	100	Хэвийн
ДҮН		100	100	1.4

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагааны нээлттэй байдал:

Тус байгууллагаар үйлчлүүлсэн иргэдээс “Тус байгууллагын албан хаагчийн нэр, албан тушаал хаягжилт гэх мэт мэдээлэл нээлттэй байсан уу” гэж асуухад 56 хувь нь “зарим мэдээлэл байсан”, 36 хувь нь “бүх мэдээлэл байсан”, үлдсэн 8 хувь нь “анзаараагүй” гэж хариулсан.




Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс иргэд, олон нийтэд зориулсан үйл ажиллагааг хэр зохион байгуулж байгааг 1-5 оноогоор үнэлүүлэхэд иргэд 2.1 оноо, ТАХ, хуульч шүүгчид 2.3 буюу дундажаас доогуур үнэлсэн байна.

Нөгөө талаас иргэдийн идэвхи оролцоог судалгаанд оролцсон иргэд, ТАХ, хуульч, шүүгчдийн 50 гаруй хувь хангалтгүй, 10 хүрэхгүй хувь нь хангалттай гэж үнэлж байна.


ТАХ, ХУУЛЬЧ ШҮҮГЧ

■ Маш муу ■ Муу ■ Дунд ■ Сайн ■ Маш сайн ■ Мэдэхгүй




ИРГЭД

■ Маш муу ■ Муу ■ Дунд ■ Сайн ■ Маш сайн ■ Мэдэхгүй



Мэдээллийн эх сурвалж:



Тус байгууллагын үйлчилгээний талаарх мэдээллийг телевиз болон цахим сувгаар авахаас гадна гар утасны апп хөгжүүлэх, ebarimt апп дээрээс авах, цахим үнэмлэхний бар кодыг ашиглан хүссэн мэдээлэл лавлагаагаа бодитой авдаг болох нь зүйтэй.

ГУРАВ. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ТАЛААРХ БУСАД ҮНЭЛГЭЭ

3.1. ШШҮХ-ийн мэдээллийн ил тод байдал, хүртээмжийн үнэлгээ

Цахим хуудасны хүртээмжтэй байдлыг хэрэглэгч харилцаж болох байдал, цахим хуудаст байх мэдээллийн хүртээмжтэй байдлын үзүүлэлтээр хэмжиж үнэлсэн болно. Цахим хуудсанд “нэвтрэх”, “бүртгүүлэх” гэсэн цонх байгаа нь хэрэглэгч чөлөөтэй харилцаж болох боломжийг бүрдүүлжээ. Өргөдөл, гомдол цахимаар гаргах боломж нь “нэвтрэх”, “бүртгүүлэх” цонхоор дамжин нээлттэй байгаа ч өргөдөлийг авсан эсэх, хаана ямар шатанд явааг хянах боломжгүй байна. Цахим хэрэглээний хүртээмжийн хувьд үндсэн цэсний мэдээлэл шинэчлэгдэхгүй байгаа нь хэрэгцээтэй мэдээлэл авах боломжийг хязгаарлаж байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагааны ил тод байдлыг байгууллагын тухай оны үйл лажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн мэдээллээр

баяжуулж тэдгээрийг ил тод байлгах шаардлагатай юм. Иргэд харилцагч байгууллагууд хөндлөнгийн хяналт тавих боломжийг байгууллагын цахим хуудас хангахгүй байгааг өөрчлөх шаардлагатай байна. Дээрх хуулийн 7.1.2-т “үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг гхүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчлэх”-ээр заасан. Энэ ажлыг хариуцсан хүнтэй байх шаардлагатай байна гэсэн үг. Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг тухайн байгууллагаас авах эрхтэй байдаг. Энэхүү иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаснаар төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг хэмжих шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдлыг өнгө, хэлбэр, загвар, хэрэгцээтэй мэдээлэл олж авч болох эсэх гэсэн хэмжээсээр үнэлсэн болно. Хайлтын систем нь хэвийн ажиллаж байгаа бөгөөд цахим хуудасны өнгө, хэлбэр хангалттай байна гэж үзэв.

Цаашид байгууллагын цахим хуудсанд байгаа мэдээллийг цаг тухайд нь шинэчилж, тусгайлан зохицуулсанаас бусад мэдээллийг ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах нь зүйтэй.

Байгууллагын цахим хуудсыг иргэд мэдээлэл авах үндсэн эх үүсвэр хэмээн үзэж, хөгжүүлэлт, сайжруулалт байнгын хийх шаардлагатай.

ДҮГНЭЛТ

Шинжилгээний байгууллагын 2022 оны “Хэрэглэгчийн үнэлгээ”-г Шүүх шинжилгээний байгууллагын үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилтийн байдал болон хамтын ажиллагаатай байгууллагуудын зүгээс иргэд олон нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдал болон дээрх асуулуудын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг 369 иргэдээс 70 орчим асуулт бүхий анкетын санал асуулга авч хуульч, шүүгч, прокурор, удирдах ажилтан экспертүүдтэй ярилцлага хийх замаар чанарын судалгаа, байгууллагын цахим хуудас ажиглалтын судалгааг хийж гүйцэтгэв.

Харин Шүүхийн шинжилгээний байгууллагад хуульчдын зүгээс өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ иргэдээс өндөр байгаа нь салбарын мэдээлэлд илүү ойр байдагтай холбоотой юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагаар 2022 онд үйлчлүүлсэн иргэдийн 47 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадсан гэж хариулсан бол 2022 оны судалгаагаар 52 хувь болж өссөн байна. Үйлчилгээ авсан иргэд дээд тал нь 5 хүртэлх байгууллага дамжсан бөгөөд үйлчлүүлсэн иргэдийн 30 хувь нь нэг удаагийн хандалтаар, 39 хувь

нь 2 удаагийн хандалтаар, 26 хувь нь 3-4 удаагийн хандалтаар, 5 хувь нь 5-дээш удаагийн хандалтаар хүссэн үйлчилгээгээ авч дуусгасан байна.

Үйлчилгээний чанар хүртээмжийн NPScore оноо иргэдийнх (-39), төрийн албан хаагч, хуульчид (-46)-аар тооцогдлоо. Энэ нь үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой хйиж байгаа ажил, гаргаж байгаа шийдвэрт шүүмжлэлтэй хандаж байгааг илэрхийлж байгаа бөгөөд гаргасан алдаа дутагдалд иргэдийн 39 хувь харьяа агентлаг, байгууллагын албан хаагч, шүүгчийн 46 хувь нь илүүтэй ач холбогдол өгч байна.

Эдгээрийг 3 бүлэг зорилтод багцлан тус бүрээр дүгнэж үзвэл:

- **Шүүхийн шинжилгээний байгууллага болон хамтын ажиллагаатай байгууллагын үйл ажиллагаанд өгсөн ерөнхий сэтгэл ханамж, иргэдийн оролцоо, аюулгүй байдал, шударга ёсны талаарх үнэлгээ**

Шүүхийн шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаатай байгууллагын үйл ажиллагаанд өгсөн ерөнхий сэтгэл ханамж, иргэдийн оролцоо, аюулгүй байдал, шударга ёсны талаарх үнэлгээ “хангалттай” хэмжээнд буюу 70%- иас 67.7%-ийн үнэлгээтэй гарч байна.

- **Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцөл, төрийн албан хаагчийн харилцааны соёл, ёс зүйн талаарх үнэлгээ**

Шүүхийн шинжилгээний байгууллагын үйлчилгээний орчин, нөхцөлийн нийлбэр дүн хамгийн өндөр буюу 3.9 гарсан. Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, харилцаа, ёс зүй, орчин нөхцөлийг үнэлүүлэхээр 18 асуулт асуухад ганцхан “Байгууллагын гадна болон доторх таних тэмдэг, тэмдэглэгээ, харагдахуйц ойлгомжтой байдал”-д иргэд сэтгэл ханамжтай байдал дундажаас дээгүүр гарсан нь 30%-ийн онооноос 26.8%-ийн үнэлгээ авч байна.

- **Төрийн байгууллагын мэдээлэл авдаг, авахыг хүсч буй сувгуудын сэтгэл ханамжийн байдал**

Төрийн мэдээллийг судалгаанд хамрагдсан иргэдийн 47% нь цахим хаягнуудаас 35% нь телевизээс авсан байна. Иргэд төрийн байгууллагын мэдээллийг цахим орчин, цахим хуудас болон телевизийн сувгаар хүлээн авч байгаа бөгөөд энэхүү хоёр сувгаар төрийн байгууллагын мэдээллийг авах хүсэлтэй байна. Иргэд төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг авах нэг суваг гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Эдгээрээс дүгнэж үзвэл Шүүхийн шинжилгээний байгууллагын нийт үйл ажиллагаа болон үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ **67.7%+26.8%=94.5%** болж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин

нөхцөл, алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн талаарх үнэлгээг хийлээ. Үнэлгээний нэгдсэн дүнгээр **94.5%** буюу **4.7** оноотой байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Шүүхийн шинжилгээний байгууллаг нь 2022 онд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ болон Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлого, чиглэлтэй уялдуулан **“Байгууллагын ажил үйлчилгээний чанарын түвшинг нэмэгдүүлж, цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож, бүх шатны удирдлагын манлайллыг дээшлүүлэх, сургалтын чанарыг сайжруулж, албан хаагчдын мэдлэг ур чадварыг ахиулах, албаны шуурхай бэлэн байдлыг хангаж, сахилга, ёс зүйг төлөвшүүлэх”** гэсэн зорилтыг дэвшүүлэн үр дүнтэй ажилласан байна.

2022 оны үйл ажиллагаагаар **“ҮР ДҮНТЭЙ”** гэсэн үнэлгээтэй гарч байгаа нь тухайн байгууллагын төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсаны илэрхийлэл юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, бүрэн хэрэгжээгүй арга хэмжээг дараа онд төлөвлөн хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байгаа бөгөөд ингэснээр **“Шүүхийн шинжилгээний байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх”** урт хугацааны зорилт хэрэгжих суурь үндэс болоход чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

---oOo---